



ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020.03.24

Даланзадгад

Өмнөговь аймгийн 2020 оны 03 ДУГААР сарын мэдээ

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл

Гадаад харилцааны чиглэлээр:

Шинэ Коронавирусын дэгдэлт БНХАУ-лс болон, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотод гарсантай холбогдуулан хамтын ажиллагаа, найрсаг харилцааны хүрээнд тус хотод хандив тусламжийн аяныг зохион байгуулж хүргүүлсэн.

Зүүн хойд Азийн бүс нутгийн захиргааны холбоотой цахимаар холбогдон 3-5 дугаар саруудад зохион байгуулагдах арга хэмжээг хойшлуулах арга хэмжээг авч ажиллалаа. Мөн БНСУ-ын Гусон хоттой хамтран ажиллах, туршлага судлах арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, мөн арга хэмжээг тодорхойгүй хугацаагаар хойшлуулахаар харилцан тохиролцож, мэдээллийг цахим хуудсаар дамжуулж ажиллав.

Нутгийн захиргааны байгууллага, өргөдөл гомдлын чиглэлээр:

Төрийн жинхэнэ албан хаагчийн улирлын ажлын гүйцэтгэлийн тайлагналтын талаар байгууллагад цахим зөвлөмж чиглэл өгч ажиллалаа. Шинэ Covid-19 вирусийн тархалттай холбоотойгоор иргэдийг аль болох олноор бөөгнөрүүлэхгүй байх, зайлшгүй биеэр ирэхээс бусад төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлэх талаар Засаг даргын дэргэдэх нийт агентлаг, төсөвт байгууллагын дарга нарт уриалга хүргүүлэн, хэрэгжилтийг нэгтгэн ажиллаж байна. Эхний 3 сарын байдлаар аймгийн ЗДТГ-т хандан иргэдээс 139 өргөдөл, гомдол ирүүлсэн бөгөөд үүнээс хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн 117, хугацаандаа яваа 22 өргөдөл, санал хүсэлт байна. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу аймгийн хэмжээний өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн эхний улирлын мэдээг сум, агентлагуудаас нэгтгэн ажиллаж байна. Цахим хэлбэрийн үйлчилгээг бодитой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс “Гэрэгэ” системс ХХК-тай холбогдон Гэрэгэ киоскыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Боловсролын чиглэлээр:

1. Даланзадгад сумын 23 дугаар цэцэрлэгийн дулааны шугамыг засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, “Хүслэн хийморь” ХХК-ийг шалгаруулан, ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, ажлыг 100 хувь гүйцэтгүүлэн хүлээн авч, цэцэрлэгийн дулааны хэвийн үйл ажиллагааг хангав. Тус ажилд орон нутгийн төсвөөс 39.2 сая төгрөгийг зарцууллаа. Булган

сумын Англи хэлний кабинетийг тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, шалгаруулан, “Нийтийн хөгжил” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг 100 хувь гүйцэтгүүлж хүлээн авав. Тус сургуулийн англи хэлний кабинетийг тоног төхөрөөмж, техник хэрэгсээр хангаж, англи хэлний сургалтын орчин нөхцөлийг сайжрууллаа.

2. Ханбогд сумын сургууль, цэцэрлэгийн засвар, Баяндалай, Баян-Овоо сумын дотуур байрны засвар, Ханхонгор сумын сургууль, дотуур байрны засвар, Даланзадгад сумын 1 дүгээр сургуульд Англи хэлний кабинет байгуулах ажил, Гашуун сухайт хилийн боомтын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг тус тус зарлаад байна.
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Ханбогд сумын дотуур байрны засвар, сургуулийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажил, Ханхонгор сумын сургуульд хөгжмийн зэмсэг нийлүүлэх ажил, Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засвар, Цогтцэций суманд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга худалдан авах ажлын тендерийг зарлаад байна.
4. Хүрмэн сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчээр “Тэлмүүн доной” ХХК-ийг шалгаруулж, ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

1.Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдал хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Коронавирусийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах, эрүүл мэндийн байгууллагын ажилчид, хилийн боомтод ажиллаж буй төрийн албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, дархлаажуулах, нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангах, хувийн хамгаалах хэрэгсэл, эм эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисийн нөөцийг бүрдүүлэн чиглэлд нийт 527,9 сая төгрөгийг зарцуулан бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

2. Халдварт өвчин голомтлон гарсан тохиолдолд ажиллах эмч эмнэлгийн мэргэжилтэн, техник хэрэгсэл болон эмнэлгийн 156 ширхэг орыг бэлтгэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 156 ширхэг ортой тусгаарлах байрыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Политехникийн коллеж, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, зочид буудалд байхаар төлөвлөн бэлтгэл бэлэн байдлыг хангасан.

3. Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын болзошгүй 10 тохиолдлыг 14 хоногын хугацаанд Оюу толгой ХХК болон Ханбогд сум дундын эмнэлэгт тусгаарлаж, тандалт, судалгаа шинжилгээнд хамруулан ажиллаа.

4. Сум багийн эмч төслийн хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар түргэн тусламжийн мотоциклоор хангах ажлыг зохион байгуулж, 14 сумын 16 багийн эмчид түргэн тусламжийн мотоциклыг хуваарилаад байна.

Соёл,спортын чиглэлээр:

1. Өмнөговь аймгийн “Хөгжимт жүжгийн театрын албан хэрэгцээнд автомашин нийлүүлэх” ажлыг “Юникплайтс” ХХК-тай гэрээ байгуулан 25 000 000 сая төгрөгийн автомашиныг 100 хувь хүлээж аван ашиглалтад хүлээлгэн өглөө.
2. Соёл спортын цогцолборын усан бассейны угсралт, тоног төхөөрөмж суурилуулах” ажлыг “Цамхаг-Өргөө”-тай гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл 30 хувьтай явагдаж байна.Төсөвт өртөг 269.7 сая төгрөг
3. “Соёл спортын цогцолборын кино театрыг байгуулах ажил” –ыг “ХНЯ” ХХК -тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр ажиллаж байна.Төсөвт өртөг 750.6 сая төгрөг

Хөдөлмөр, халамж:

1. Өрх гэр бүлийн хөгжлийн жилийн нээлтийг 2020 оны 03 сарын 09-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж олон нийтэд хүргэлээ.
2. Дэмжих жилийн ажлыг олон нийтэд хүргэх зорилгоор орон нутгийн 9 хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, нийт 26 сэдвээр сурталчилгааны материал бэлтгэн цахимаар олон нийтэд хүргэж ажиллалаа.
3. “Хөгжлийн ирээдүй Оюунлаг залуучууд” хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувийн туслахын урамшууллыг олгож эхэллээ.
4. “1 өрх- 1 ажлын байр”, Заавал хөгжих зорилтот өрх”, “Хүүхдийн эрсдэл”-ийн программыг нийлүүлэх, аймгийн ахмадын хороонд хөгжим, техник хэрэгсэл нийлүүлэх, аймгийн ахмадын хороонд автомашин нийлүүлэх гүйцэтгэгч нарыг шалгаруулж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Хууль эрх зүйн чиглэлээр:

1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх “Хууль зүйн луужин” цахим хуудсыг нээж ажиллуулсан. Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий цэгийн үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 10-аас 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаагаар зогсоох ажлыг зохион байгуулсан.
2. Нөөцийн мах худалдаанд гаргах ажлын хэсэгт орж ажилласан.
3. Хүнс ногооны механикжсан зоорийг менежментийн гэрээгээр эзэмших хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэг ажилласан.
4. Мах, өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх ажлын хэсэгт ажиллаж, үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.
5. 2020 оны 03 дугаар сарын 10, 03 дугаар сарын 24-ний өдөр шуурхай штабын 24 цагийн жижүүрээр тус тус ажилласан.
6. “Ажнай корпораци” ХХК, “Хар алтан уул” ХХК, “Анзаот” ХХК нарын нэхэмжлэлтэй газрын маргаанд хариуцагчийг төлөөлөн ажиллаж байна.
7. Номгон сумын Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй 9 иргэн, хуулийн этгээдээс төлбөр гаргуулах нэхэмжлэлийг иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан.

8. Төрийн архивын байрны хэсэгчилсэн засварын ажлыг хийж гүйцэтгэв. Мөн шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулж ажиллав.
9. 2019 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн зураг. төслийн баримтыг тоо бүртгэлд оруулсан.
10. 53 хүний архивын лавлагаа, 158 хуулбар гаргаж иргэдэд үйлчилсэн байна.

Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

1. Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 2-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа
2. Нийт 43 төсөвт байгууллагуудын 2020 оны 2 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан.
3. Төсвийн орлогын 2-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулсан.
4. Орон нутгийн байгууллагуудын 2 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ.
5. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 3-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
6. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 3-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
7. Аймгийн төрийн сангийн харъяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа.
8. Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрибаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа.
9. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн.
10. 2019 оны жилийн эцсийн тайланг аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудаас хүлээн авч нэгтгэн ажиллаж байна.

Сум, багийн мэдээлэл:

БАЯН-ОВОО СУМ

Сумын Засаг даргаас А захирамж 14, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 8-ийг тус тус гаргасан байна. Цаг үеийн мэдээллээр сумын онцгой комиссын бие бүрэлдэхүүн болох байгууллагын дарга эрхлэгч нар 7 хоногт 2 удаа хуралдаж тогтмол мэдээлэл солилцож ажилласан. БСУГ-аас ЕБДС-н бүсчилсэн онлайн хурлыг сургуулийн захирал Ц.Нарантуяа, Нягтлан бодогч Б.Нарангэрэл, Нийгмийн ажилтан О.Нандинцэцэг нар 03 сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Нийт байгууллагын албан хаагчид сумын орох гарах хөдөлгөөний замуудын дагуух хяналтын цэгүүдэд хуваарийн дагуу ажилласан. Эрүүл мэндийн төвөөс нийт

байгууллагын албан хаагчид сумын орох, гарах хөдөлгөөний зам дагуух хяналтын цэгүүдэд хуваарийн дагуу ажилласан. 2020 оны 02 сарын 21-ны өдрөөс 03 сарын 16 ны өдөр хүртэл COVID-19 өвчний тархалтыг зогсоох УОК-ын шийдвэрээр хөл хорио тогтоож төрийн албан хаагчдыг бүрэн бүрэлдэхүүнтэйгээр сумын орох гарах замуудад 6 шалган нэвтрүүлэх цэг гарган цагдаагийн хэлтэстэй хамтран өндөржүүлсэн бэлэн байдлаар ажилласан. Тус сумын төллөвөл зохих 65926 хээлтэгчээс 5, 4 хувь нь буюу 3540 мал төллөж, 3542 төл /ботго-55,хурга-2289, ишиг-1198 / гарч эсэн мэнд бойжиж байна

Сумын нөөцөд бэлтгэсэн 40 тн өвс, 30 тн тэжээлийг малчиддаа хуваарилж тарааж өгсөн. Одоо үлдэгдэл 500 боодол өвс байна.

МЭҮТасгийн мэргэжилтэн болон багуудын малын эмч нар малчдын дуулагын дагуу 6 удаа багт явж үйлчилсэн. Үүнээс 5 удаад нь тэмээ галзуурах, үнэг галзуурсан дуудлагаар явсан байна.

ЕБДС-ийн нийт багш ажилчид өөрсдийгөө хамгаалах үүднээс амны хаалтыг бэлтгэж, 1 хүн 6 ширхэг маск гараар оёж, хяналтын постонд ажиллах хугацаандаа тогтмол хэрэглэсэн. 2020 оны 03 сарын 10-ны өдрөөс 03 сарын 16 ны өдөр хүртэл COVID-19 өвчний тархалтыг зогсоох УОК-ын шийдвэрээр хөл хорио тогтоож төрийн албан хаагчдыг бүрэн бүрэлдэхүүнтэйгээр сумын эргэн тойронд 6 пост гарган цагдаагийн хэлтэстэй хамтран ажилласан.

ЕБС-ийн нийт 20 багш ажилчид удирдлагын хамт сумын зүүн хойд Ханхад, зүүн урд Хүүхдийн овоо гэсэн 2 постонд 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр өдрийн 8 цагаар ажилласан бөгөөд шалган нэвтрүүлэх хяналтын цэгт ариутгал цэвэрлэгээ халдваргүйжилт хийж, амны хаалтыг байнга хэрэглэж, постоор орж гарах иргэдэд зөвлөмж зөвлөгөө өгч, аюулгүй байдлыг хангаж ажилласан. Аймгийн хэмжээнд хөл хориог 2 удаа тогтооход сумын 6 постонд эмнэлгийн 20 эмч, ажилчид 6 болон 8 цагийн зайтай ээлжинд гарч жижүүлсэн бөгөөд жижүүрийн бүх хугацаанд гарсан зөрчилгүй тайван байсан.

Сумын төвийн нийт айл өрхүүдийн гадна хашаан дээр 65 ширхэг коронавирусээс сэргийлсэн зурагт хуудас, зөвлөмжүүдийг нааж байрлуулсан.

Коронавирусын голомттой бүс нутаг болох Дорноговь аймагт алтанд яваад ирсэн 2 иргэнийг хөдөө очиж үзлэгт хамруулж, гэр болон машиныг халдваргүйжүүлж, гэрт нь 14 хоног тусгаарлах зөвлөмж өгсөн. Мөн Манлай сумруу алтанд яваад ирсэн гэсэн өгүүлэмжтэй 3 иргэнийг сумын хойд талын постон дээр очиж үзлэгт хамруулан, машиныг нь халдваргүйжүүлэн мөн тус бүрийг гэрт нь 14 хоног тугаарлах зөвлөмжийг өгч хяналт тавин ажилласан.

Өдөр бүр коронавирусын холбогдолтой болон бусад төрлийн шинэ мэдээ мэдээллийг эмнэлгийн фэйсбүүк болон пэйж хуудсанд байрлуулж, коронавирусын үед хэрэглэх хамгаалах хувцас өмсөх, тайлах сургуулилтыг хийж байна. Дээр дурьдагдсан Covid-19 халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, багш ажилчдыг эргүүлд гархад эргүүлийн байрын эрүүл, аюулгүй байдлыг хангахад чигэлсэн дараах ажлыг зохион байгуулж ажиллаа.

- Гар угаах угаалтуур
- Ус /шанга/
- Саван

- Гар уриутгагч
- Нэг удаагийн бээлий
- Эргүүлийн хантааз, дохиур мод
- Постны байрыг ариутгаж цэвэрлэх /хувин, шалны мод, цэвэрлэгээний бодис/ гм хэрэглэлээр хангаж ажилласан. Мөн анги бүлгүүдийн ариун цэвэрт Сургалтын менежерээр ахлуулсан дотоодын хяналтын ажилтан, ХАЭАЗ-ийн дарга нарын бүрэлдэхүүн хяналт шалгалт хийж ажиллалаа. Энэ үзлэгээр анги бүлэг, ажилчдын өрөө тасалгаанд гарсан зөрчил, дутагалыг арилгахад анхааруулж санууллаа.

Бүлгийн багш ангийн хүүхдүүдийг эргэх, 1-р улиралд хэрэглэгдэх сургалт болон ариун цэвэрийн хэрэглэлийг тараах ажлыг зохион байгууллаа. Бага бүлгийн ЭЭЗдарга П.Оюун-Эрдэний санаачилгаар “Тоглоомын эзэд” төслийг хэрэгжүүлж 5500.0 төгрөгний хөрөнгө оруулалт хийгдлээ.

БУЛГАН СУМ

Энэ сард сумын Засаг даргаас А захирамж 3, Засаг даргын Тамгын газрын даргын Б тушаал 1 тус тус гарсан байна.

Шинэ төрлийн коронавирусын халдвараас сэргийлэх Улсын онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын захирамжийг орон нутагт хэрэгжүүлэн 2 дугаар сарын 27-ноос 3 дугаар сарын 3 хүртэл 46 хүн, 3 дугаар сарын 10-наас 3 дугаар сарын 16 хүртэл 66 хүн сумын төвийн орох, гарах авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлан 24 цагаар 5 постод ажиллав.

2 дугаар сарын Орон нутгийн орлогыг хаалтын дансруу хааж, гүйцэтгэлийг татварын байцаагчтай тулган аймагт мэдээлэв. Аймгаас ирсэн 2020 оны 3 дугаар сарын санхүүгийн дэмжлэгийг орлогын дансанд хааж, орон нутгийн байгууллагын санхүүжилтийг олгов.

2020 оны 2 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт байршуулж, байгууллагуудын шилэн дансны мэдээлэлд хяналт тавьж ажиллав. Сумын тусгай сангууд болон санхүүгийн нэгдсэн тайланд аудит хийлгэж, судалгаануудыг бөглөж явуулж байна. ЗДТГазрын нэмэлт дансанд ирсэн санхүүжилтийн эрхийг нээлгэн гүйлгээг хийж байна.

Эрүүл мэндийн төвийнжЭмчийн үзлэгт 165 хүнийг хамруулсан. Түргэн тусламжийн дуудлага 9 ирж тусламжийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлсэн. Товлолт дархлаажуулалтын вакцинд 30 хүүхдийг хамруулаад байна. Нийт 18 жирэмсэн эхийг хянаж байна. Хамгаалах хувцасыг өмсөх тайлах дарааллаар дотоодын сургалыг 2 удаа зохион байгууллаа.

ГУРАВАНТЭС СУМ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр хуралдаж 4 асуудал хэлэлцэж баталсан байна.

- Сумын Засаг даргаас 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/13 захирамжаар малын халдварт галзуу өвчний хязгаарлалтын дэглэм тогтоох тухай
- 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/16 өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай
- 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/19 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай захирамжуудыг гаргасан байна.

Сумын Засаг дарга 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах 2020 оны гэрээ байгуулсан бол 2020 оны 02 дугаар сарын 14-нд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцож 15 асуудал хэлэлцэж баталсан.

Сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/13 захирамжаар малын халдварт галзуу өвчний хязгаарлалтын дэглэмийг 14 хоногийн хугацаатай тогтоосон бөгөөд галзуу чононд бариулсан 3 айлын 5 малыг шатааж устгаж, ариутгал, халдваргүйжүүлсэн. Мөн 3 айлын 5 малчныг галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад хамруулж, зөвлөгөө өгч гарын авлага тараасан. Тухайн айл өрхүүд 14 хоногийн хугацаанд малаа байнгын маллагаа, хариулгатай байлгаснаар өвчин дахин гараагүй тул сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/19-тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг цуцалсан.

2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/16 өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай захирамжийг гаргаж сумыг бэлэн байдлын зэрэгт шилжин эргүүлийн хуваарь гарган холбогдох байгууллагад өдөр бүрийн 10, 12, 14, 16, 18, 20 цагуудад мэдээ өгч ажиллаж байгаа бөгөөд уул уурхайн компаниуд, Шивээ хүрэн хилийн боомтод сумын онцгой комиссоос ажлын хэсэг ажилласан.

Улсын онцгой комиссоос ажлын хэсэг Шивээ хүрэн боомтод 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ажилласан.

ДАЛАНЗАДГАД СУМ

Даланзадгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 06, 07 дугаар хурал хуралдаж тус бүр 3 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, сумын Засаг даргын А захирамж-118 Б захирамж-2, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал-16, Б тушаал-3 тус тус батлагдан гарч, 2020 оны 03 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 81 албан бичиг хүлээн авснаас 51 бичиг нь хариутай. Хариутай бичгийг заасан хугацаанд шийдвэрлэсэн байна. Сумын Засаг дарга болон Тамгын газраас 107 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Ирсэн санал, өргөдөл гомдол 8, Шийдвэрлэж хаасан 1, Хугацаандаа яваа 7 санал өргөдөл байна.

Сумын удирдлага, холбогдох мэргэжилтнүүд аймгийн Онцгой комиссын өргөтгөсөн хуралд оролцож, хөдөлгөөнт болон суурин эргүүлийн томилгоо, аюулгүй ажиллагааны талаар 3-н санал оруулж батлууллаа.

2020.03.16-нд Даланзадгад сумын удирдлагууд хотын Захирагчийн ажлын албаны дарга болон чиглэлийн мэргэжилтнүүдэд ажилчдын Эрүүл мэндийг хамгаалах, ХАБ, хийгдэж байгаа ажлын талаар мэдээлэл солилцож үүрэг чиглэл өгч ажиллаа.

Даланзадгад сумын удирдлагууд тус суманд үйл ажиллагаа явуулдаг ШТС-ын дарга, эрхлэгч нарыг хүлээн авч уулзан шинэ корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэл өгч, шатахууны хомстол үүсэхээс урьдчилан сэргийлж нөөц бүрдүүлэн ажиллахыг үүрэг болгон хамтран ажиллах гэрээ байгууллаа. Мөн тус суманд үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкны удирдлагуудыг хүлээн авч уулзан шинэ корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэл, банкаар үйлчлүүлж байгаа иргэдэд тавих шаардлагыг өндөржүүлэх, АТМ-ны ариутгал, банкнаас тавих хяналтыг сайжруулах чиглэлээр санал солилцлоо.

Даланзадгад сумын ЗДТГ өөрийн харьяа байгууллага Захирагчийн ажлын алба, Говийн ирээдүй ОНӨААТҮГ-ын дарга, 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан, Зохион байгуулагч, ЗДТГ-ын бодлогын мэргэжилтнүүдтэй 2020 онд хамтран ажиллах гэрээ, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө байгууллаа.

“Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг улсын хэмжээнд зарласантай холбоотой салбарын мэргэжилтнийг чадавхжуулах “Үрслэг тариалах технологи”-ийн талбайн сургалт “Хүлэмжийн цогцолбор аж ахуйн талбай”-д 2020.03.07-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд мэргэжилтэн Ч.Дүүрэнжргал хамрагдлаа.

Шинэ коронавирусын халдвараас сэргийлэн Өрхийн ЭМТөвүүдийн үзлэгийн хуваарьт 2020 оны 03 сарын 11-с эхлэн харьяалал харгалзалгүй үзлэг хийхээр өөрчлөлт орууллаа.

Энхийн хүслэн ӨЭМТөв аймгийн төвийн бүх жирэмсэн эхчүүдийн үзлэг, 3-р багийн Шимбилэгийн салбарт зөвхөн дархлаажуулалт, Шим билэгийн 8-р багт өвчний учир, Өнө орших зорилтот үзлэгийг өдөр бүр хийж байна.

Шинэ коронавирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Даланзадгад сумын хэмжээнд 108 ортой ажиглах байрыг Политехник коллежийг түшиглэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах тухай хууль, Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор “АЙМГИЙН ХЭМЖЭЭНД СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ” аймгийн Засаг даргын захирамж гарч, согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд хүргүүлэн, Даланзадгад хотын төвд согтууруулах ундаа зарж борлуулах болон үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй болон хууль бусаар согтууруулах ундаа зарж борлуулдаг 108 цэгийн судалгааг гаргаж, теле камерын 24 цагийн хяналтад авч ажиллаж байна. Согтууруулах ундаа зарж борлуулсан, үйлчилсэн аж ахуйн нэгж болон, хууль бусаар гар дээрээс согтууруулах ундаа зарж борлуулсан иргэдийн талаарх мэдээллийг 89025494, 89825282 дугаарын утсанд иргэдээс төлбөртэй авч байна.

Б.Төмөрбат даргатай “Буянт хотхон” УТҮГ-ын хамт олон 108 ширхэг амны хаалт /маск/, Даланзадгад сумын Дэлэгийн нэрэмжит Л.Байгалмаа эрхлэгчтэй 9-р цэцэрлэгийн хамт олон өөрсдийн гараар урласан 70 ширхэг амны хаалт /маск/, Даланзадгад сумын сургуулиудын Түүх, Газар зүйн багш нарын “Эх түүхийн жим Эко аялал” клубээс Сумын шуурхай штабт 2-6 настай хүүхдэд таарах 50 ширхэг амны хаалт /маск/, Ц.Хөхөө захиралтай “ТАНГАД РА” ХХК-ны хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд Даланзадгад сумын ЗДТГазрын албан хаагчдад дархлааг дэмжих 300 уут ааруултай кальцыг Даланзадгад Сумын шуурхай штабт хүлээлгэн өглөө.

Хилийн 0131-р ангийн ажилчдын байрны гадна талбайн тохижилт, цайны газрын байрыг засварлах, ЗДТГ-н иргэний танхимыг засварлан тохижуулах, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах, Захирагчийн ажлын албаны конторт техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил нийлүүлэх, 3-р сургуулийн биеийн тамирын талбай байгуулах ажлын сонгон шалгаруулалтуудыг зарлаад байна. Зэвсэгт хүчний 0167-р ангийг камержуулах ажлын тендерийн нээлт, шалгаруулалтыг хийж, гэрээ байгуулах шатандаа явж байна.

Даланзадгад сумын 2020 оны төсвийн орлогын төлөвлөгөө 817789.2 мян.төгрөг гүйцэтгэл 372840.3 мян.төгрөг болж 45.6 хувь биелсэн, өөрийн орлогын төлөвлөгөө 1667.0 мян.төгрөг, гүйцэтгэл 519.3 мян.төгрөг 31.2 хувьтай байна.

Аймаг, сумын Шуурхай штабт ажиллах эргүүл, жижүүрийн томилгоог гаргаж үүрэг, гүйцэтгэлтэд тогтмол хяналт тавьж, давхардсан тоогоор 148 албан хаагч, Хөдөлгөөнт постуудад төрийн албан хаагчдыг 12 цагаар ажиллуулж үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавьж, 51 албан хаагч үүрэг гүйцэтгэлээ.

Даланзадгад сумын Засаг даргын 2020 оны А/41 дүгээр захирамжийн дагуу сумын харьяа 6 сургуулийн 216 багш, ажилчдыг 2020.03.11-16-ны өдрүүдэд сумын “Олон нийтийн эргүүл”-д дайчлан ажиллуулж 72 зөрчил илрүүлж, алдаа дутагдлыг тухай бүр арилгуулан ажиллаа.

Даланзадгад сумын Засаг даргын 2019 оны А/64 дүгээр захирамжийн дагуу сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг нийт 183 байгууллага аж ахуй нэгж байгууллага орчны 50м газрын хог хаядалыг цэвэрлэж нийт 113 тонн хог хаягдалыг цэвэрлэж хогийн цэгт төвлөрүүлээ.

Гарал үүслийн 9 гэрчилгээнд баталгаажуулалт хийж, 850 ишгэнд шөвөг ярын вакцинд хамруулаад байна. Том малын хорогдол 157 толгой мал байна. Улсын нөөцөөс сумдад хувиарласан 500 боодол өвс, 250 шуудай хивгэн тэжээл, эрдэс долооцыг аймгийн нөөцийн газраас хүлээн авч, малчдад 2020.04.01-ээс хувиарлахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Хог ачилт хуваарийн дагуу явагдаж байна. 3 сард нийт 4055 тонн хог хаягдал тээвэрлэн ангилан ялгалт хийгдэж байна. Даланзадгад сумаас цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа 12 иргэнийг “Цэргийн дайчилгаа”-гаар 14 цагийн ажил хийлгэлээ. 2020.02.28-29-ний өдрүүдэд 8 багийн нутаг дэвсгэрт нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулан 116,3 тн хог хаягдлыг хогийн цэгт төвлөрүүлээ. 2020.03.01-нд 8 багийн хэмжээнд 5732 өрх, 77 Аж ахуйн нэгжийн агаарын нэгдсэн тоо бүртгэлийн судалгааг гаргаж холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаа. 2020.03.12-нд “Оюу хүлэмж-2” төсөлд хамрагдах хүсэлтэй 23 иргэний судалгааг сумын ЗДТГ-т хүргүүлээ.

МАНЛАЙ СУМ

Сумын Засаг даргаас А захирамж 6 гарч батлагдав. Үүнд: “Шинэ короновирусын халдвараас урьдчилан сэргийлж игэдийг амны хаалт /маск/ зүүж хэвшүүлэх тухай, Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах тухай, Өрх гэл бүл хөгжлийн жилийн ажлыг суманд зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай, Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, жижүүрийн хуваарийг батлах тухай, Худалдаа үйлчилгээний байгууллагын ажиллах цагийн хуваарь, архи согтууруулах ундаа, түүгээр үйлчлэхийг хориглох тухай, Боловсрол, соёл урлагийн ажилчдыг дэмжих жилийн ажлыг суманд зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Сумын Засаг даргын Тамгын газрын А тушаал 3 гарсан байна.

Сумын онцгой комисс 3 удаа хуралдаж КОВИД-19 вирусны талаархи мэдээ мэдээллийг солилцож сумандаа шуурхай арга хэмжээ авч, сумын Шуурхай штаб ажиллаж, сумын хэмжээнд 2 удаа пост хуваарийн дагуу гаргаж хөл хөдөлгөөнийг хааж арга хэмжээ авч ажиллалаа. Байгууллагын дарга, эрхлэгч, мэргэжилтнүүдэд ТАХ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний талаар сургалтыг орсон. Нийт 20 албан хаагч

хамрагдсан. Сумын ХШҮ-ний нэгжийн дарга нэгжийн 4 гишүүнд нэгжийн ажлын чиглүүлэх сургалтыг орсон. Цэцэрлэгийн 2 багш мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхээр 2020 оны 03 сарыни 16-ны өдрөөс Монголын Хүний Нөөцийн Удирдлага Шинэчлэлийн Академийн-“Сургуулийн өмнөх боловсролын бүлгийн багш” мэргэжлээр эчнээ ангид элсэн орж онлайнаар суралцаж байна. Цэцэрлэгийн багш ажилчдад 2020 онд байгуулах төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах заавар зөвлөгөөг 2020 оны 03 сарын 16-ны өдөр зохион байгуулж 2020 оны 03 сарын 23-ны өдөр гэрээг албан ёсоор байгуулахаар төлөвлөн ажилласан.

2020 сонгуулийн хэсгийн хороо, салбар хороодод ажиллах төрийн албан хаагчдын нэрсийг гаргаж аймгийн ИТХуралд 55 нэрс хүргүүлсэн.

Цогтцэций, Манлай сумын хооронд зам дагуу байрлах 24 цагийн байнгын постын тоног төхөөрөмж худалдан авах болон ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулан холбогдох материалуудыг бүрдүүлж ажилласан. Алдарт эхийн одон шинээр авах 16 эхийн материалыг хугацаанд нь бүртгэн авч дараагийн шатны байгууллагад хүргүүлсэн. Нарийн бичгийн дарга иргэний танхимд ЗДТГ-ын хууль эрх зүй хариуцсан мэргэжилтний зохион байгуулсан и-оффис программын хэрэглээ болон и-хөтөч цахим мэдээллийн сангийн тухай сургалтад хамрагдаж мэдээ мэдээллээр хангагдсан. Улаан загалмай, гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх зөвлөл, мини парламентын самбаруудыг шинэчилж, мэдээллүүдийг оруулж, сонгуулийн байгууллагад ажиллах ажилтнуудын сургалтын онлайн бүртгэлийг шинээр хамрагдах 16 төрийн албан хаагчдад цахимаар танилцуулан хамруулсан. ИТХурлын дарга болон нарийн бичгийн дарга сумын онцгой комиссоос гарсан шийдвэр хуваарийн дагуу эргүүл постонд гарч үүрэг гүйцэтгэсэн. Улаан загалмайн дунд шатны хороонд өвөлжилтийн мэдээ болон зорилтот бүлгийн ахмадын судалгаа-21, сайн дурын идэвхтний судалгаа-7 тус тус гаргаж хүргүүлсэн. Аймгийн ИТХурал болон Архивын газруудад 2019 оны тогтоолууд болон мөрдөгдөж буй захиргааны хэм хэмжээний актууд, малчдын бүлэг хэсгүүдийн мэдээллийг хүргүүлж судалгаанд хамрагдсан.

Байгууллагын ажилчдынхаа дархлааг дэмжиж ханиад томуунаас сэргийлэх зорилгоор албан хаагч бүрт 500мл –ын чацаргана, Зөв аарцыг тараасан.

Засаг даргатай , Засаг даргын орлогч, БЗДарга нар, Байгууллагын дарга, эрхлэгч нийт 10 төрийн албан хаагч гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулж гэрээгээ байгуулсан.

Сумын ХШҮ-ний нэгжийн ажлын хэсгийг шинэчлэн байгуулж 1 удаа хуралдаж жилийн төлөвлөгөөгөө ярилцсан.

Байгууллагын дотоод сургалтыг 1 удаа зохион байгуулсан.

Авлигын эсрэг үйл ажиллагааны 1-р улирлын тайланг ХЭЗХ-т бичиг хэргээр дамжуулан и-оффис програмаар хүргүүлсэн.

Мэргэжилтнүүд 2-р сарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ гаргасан.

Аймгийн Засаг даргын 1-192-р тоотын дагуу “Үгүй гэж хэлье” аяныг төсөвт 6 байгууллагуудыг хамруулан төлөвлөгөө гарган зохион байгуулж байна.

Сумын шуурхай штаб өдөр бүр хуваарийн дагуу ажиллаж мэдээгээ аймагруу өгч байна.

Сумын хэмжээнд 2 удаа пост гарган хуваарийн дагуу ажилласан бөгөөд 1-р ээлжийн постонд 89 төрийн албан хаагчид үүнээс эр-25, эм-64, 2-р ээлжийн постонд 101 албан хаагч үүнээс эр-36, эм-65 нийт давхардсан тоогоороо 190 төрийн албан хаагчид ажиллаж сум орон нутгийнхаа ажилд идэвхитэй оролцож үүргээ гүйцэтгэсэн.

Шинэ коронавирусын болзошгүй тохиолдлын бэлэн байдлыг хангах зорилгоор тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж ажиллаж байна. Тусгаарлах өрөөний бэлэн байдлыг 7 хоног бүр үнэлж байна. 2020 оны 3-р сарын 13-ны өдрийн байдлаар үнэлэхэд 86,3%-тай байна. Мөн эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг нэг удаагийн хамгаалах хэрэгсэл өмсөх тайлах дарааллыг зөв эзэмшсэн эсэхэд тандалт хийх үнэлгээний хуудсаар үнэлэхэд 95%-тай байна.

Шинэ коронавирусын болзошгүй тохиолдолын үед эмнэлгийн ор дэлгэх, эмнэлэг нүүлгэн шилжүүлэн бэлтгэл ажилаа хангаж байна. одоогоор Соелын төвд 20 ор дэлгэхээр, ЭМТ-д 36 ор дэлгэхээр ажиллаж байна. мөн цаашлаад Спорт заал, Дотуур байр зэргийг бэлтгэхээр ажиллаж байна.

Шинэ вирусээс урьдчилан сэргийлэх хүрээнд 34 ААН, албан байгууллага, олон нийтийн газруудыг ариутгал халдваргүйтгэлийн хийсэн. Үүнд 15480 кв талбайг ариутгаж халдваргүйтгэсэн байна.

Шинэ коронавирусын өндөржүүлсэн бэлэн байдлын үед халдвараас сэргийлэхийн тулд сургуулийн 2979 м², дотуур байрны 1048 м², спорт залны 1254 м² талбайг сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ариутгалыг хийлгэв.

Хичээл орох хугацааг сунгасантай холбогдуулан ТҮ хичээлийн хуваарийг анги удирдсан багш нарт групп чатаар тараан анги удирдсан багш нараас ТВ хичээл үзэж байгаа сурагчдын судалгааг утсаар авч нийт 350 суралцагчдаас 275 сурагч үзэж тэмдэглэл хөтөлж байгаа сурагч 79,0 хувьтай байлаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед 6 хяналтын постонд тус сургуулиас давхардсан тоогоор 28 багш ажилчин ээлжийн үүрэг гүйцэтгэв.

Ангийн багш нар 7-14 хоногийн даавгавар бэлтгэн хүүхэд бүрт хүргэж ажиллалаа. Цэцэрлэгийн хэмжээнд нийт 180 хүүхэд байгаагаас 130 хүүхдэд даалгавар тараасан. Үлдсэн 50 хүүхэд хөдөө сумаас зайдуу байгаа учир хүргэх боломжгүй байна. Эцэг эхтэй утсаар холбогдож суман дээр орж ирсэн тохиолдолд хүүхдийн даалгавараа авч явах талаар мэдээлэл хүргэсэн.

Ангийн групп чатад өдөр бүр зөвлөгөө, мэдээлэл тавьж, харилцан мэдээлэл солилцож байна.

Байгууллагын багш ажилтныг суманд үйл ажиллагаа явуулж байгаа зам ангийн ариутгалын постонд 2020 оны 03 сарын 16 –ны өдрөөс эхлэн 31–ныг дуустал 24 цагаар хуваарилан ажиллуулж байна. Нэгдүгээр улирлын байдлаар 138 уншигч, иргэдэд 414 ном олгож үйлчилсэн байна. Уншигч иргэдээс шинэ номын захиалга авч байна. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг болон бусад 6 хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Байгууллага өдөр бүр халдваргүйжүүлэлтийн цэвэрлэгээ үйлчилгээ хийгдэж байна. Сумын Эрүүл мэндийн төвөөс коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан

сэргийлэх арга хэмжээ авч манай байгууллагын 5 өрөөг суллаж тандалт хийхээр төлөвлөн бэлтгэж байна. 20 иргэн ирж үйлчилгээ авсан. 7 гэрчилгээ захиалсан, 3 газар дээр нь очиж хэмжилт хийсэн.

19 аж ахуйн нэгжийн газрыг талбайн хэмжээ алдаатайг засан залруулж газрын төлбөрийг нэгтгэн оруулсан

Уурын зуух болон цэвэрлэх байгууламжийн судалгаа гаргаж, өмчлөлийн 5 иргэний өргөдөл хүлээн авсан. Эрх шилжих 4 иргэний өргөдөл хүлээн авч, Кадастр хийгээгүй аж ахуй нэгж болон иргэнд мэдээ хүргүүлсэн. Өмчлөлийн газар талбайн хэмжээ сунган татсан айлыг буцаан татуулсан. 52 иргэн болон аж ахуй нэгжийн газрын талбар дээр 105 нэхэмжлэл үүсгэн ажилласан.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 218 малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид даатгуулсан.

Эрүүл Мэндийн Даатгалд 180 малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид даатгуулж, ажилгүйдлийн тэтгэмж 3 иргэнд 3031781 төгрөгийг олгосон.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 50 иргэнд 9266580 төгрөг, НМТэтгэмж 50 иргэн 5392000 төгрөг, ХБИргэний хөнгөлөлт 1 иргэн 20000 төгрөг, 172-н Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмж 8407080 төгрөг, 1 ахмадад Гавьяат цолтон ахмад настанд үзүүлсэн мөнгөн тусламжийн 150000 төгрөг тус тус олголтын жагсаалтыг үүсгэсэн ХХҮГазарт хүргэсэн.

Ажил хайгчаар бүртгэлтэй 5 иргэнийг Монголын Төмөр зам” ТӨХКомданид үйлчлэгч, бэлтэгч тогоочийн ажилд, 3 иргэний анкетыг хүргүүлсэн.

Нийгмийн асуудал:

- 2018-2022 онд хэрэгжих “Үндэсний хөтөлбөр”-4, Засгийн газрын тогтоол-2, албан даалгавар-2 тус тус хяналтандаа авч төлөвлөгөө гарган батлуулсан. 2016-2020 он хүртэл хэрэгжих өөрт хяналтанд авсан хөтөлбөр тус бүрийн төлөвлөгөө гаргаж Засаг Даргаар батлуулсан. “ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” /6/, “АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР” /3/ тус тус төлөвлөгөө гаргасан. Нийт Үндэсний хөтөлбөр 10, Аймгийн дэд хөтөлбөр 3, Засгийн газрын тогтоол 2, Албан даалгавар 2 батлуулсан.

Төсөв санхүүгийн талаар:

Манлай сумын төсвийн орлого

2020 оны 02-р сар

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Сараар
Орлогын албан татвар	950,100	827,653	256500
Үйл ажиллагааны орлого	200,000	9,500	9,500.00
Нэр заагдаагүй орлого	0	0	0
Шууд бус орлого	750,100	818,152.60	247,000
Өмчийн албан татвар	556,200	30,000	0
Бууны албан татвар	556,200	30,000	
Бусад татвар төлбөр хураамж	4,300,000	974,670	254,151
Улсын тэмдэгтийн хураамж	300,000	166,000	17,500
Ойгоос түлээ мод ашигласаны	0	0	0

төлбөр			
Агнуурын нөөц ашигласаны төлбөр	0	0	0
Тусгай зөвшөөрлийн төлбөр		0	0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласаны төлбөр	0	3300	
Хогийн төлбөр	4,000,000	736,000	228,500
Ус рашааны ашигласны төлбөр		69,370	8151
Татварын бус орлого	133,542,900	28,875,584.64	5,797,607.27
Хадгаламжийн хүүгийн орлого	10,504,400	13,900,184.64	4,955,207.27
Бусад хүү торгууль	122,538,500	14,638,000	790,000
Түрээсийн орлого	500,000	267,400	22,400
Хөрөнгийн борлуулсны орлого		70,000	30,000
Төсөвт газрын өөрийн орлого	0	0	0
Суманд төвлөрүүлэх орлого	139,349,200	30,707,907.24	6,308,258.3
Сум хөгжүүлэх сангийн орлого	0	4,473,275	3,823,225

ШИНЭЛЭГ АЖИЛ:

Байгууллагын дарга эрхлэгч нарт Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн И-ОФФИСС ПРОГРАММ-ын ашиглалт, хэрэглээ болон И-ХӨТӨЧ эрх зүйн цахим мэдээллийн санг танилцуулж гарын авлага тараасан. Нийт 15 дарга, эрхлэгч, мэргэжилтнүүд хамрагдсан. Соёл олон нийтийн үйл ажиллагаа хориглосон учир Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр буюу ЗХ-ний 99 жилийн ойн баярын өдрүүдийг тохиолдуулан Онлайнаар уралдаан зарлаж шалгарууллаа. Үүнд: “Ээждээ өргөх дуу”-ны уралдааныг зарлаж 5 авьяастан оролцож ээждээ зориулж ая дууг өргөж оролцсон. “Хүний дээд аавтайгаа” фото зургийн уралдаанд нийт 72 зураг ирсэн. Тус бүр хамгийн олон лайк авсан эхний 3-г шалгаруулсан. Мөн “Аавдаа бичих захидал”- онлайн уралдааныг зарлаж бичсэн захидалыг хөгжим, бүжгийн багш нар хүлээн авч ая, дууны найруулга хийж ирсэн захидалыг уншиж фэйс хаягт байрлуулж мөн хамгийн лаякаар шалгаруулахаар хүлээн авч байна. Номын сангаас байгууллагын фэйс хаяг буюу онлайнаар Манлай сум “Нийтийн номын сан цахим уншлага” ажиллуулж 6 өгүүллэг бичиж оруулж иргэдэд хүргэж байна. Багт хийгдсэн ажлууд: 4 багийн эмч нар “ДЭМБ”-ээс санхүүжүүлсэн мөнгөн дэмжлэгээр айл өрхүүдээрээ гэрийн эргэлтийг сар бүр хийж байна. Энэ сард зорилтот бүлгийн 18 өрхөд гэрийн эргэлт хийсэн байна.

МАНДАЛ-ОВОО СУМ

- Сумын Засаг даргын захирамж 14, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 4 тус тус гарсан байна. Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 2, албан байгууллагын дарга эрхлэгчдийн хурал цуглааныг 3 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлаар ярилцаж шийдвэрлэсэн.
- ХӨСҮТөвөөс гаргасан Ариутгал халдваргүйжүүлэлт хийх зааварчилгааг бүх байгууллагат хүргүүлж, зорчих хөдөлгөөнийг түр хязгаарласантай

холбогдуулан 4 хяналтын пост гаргаж, түүнд 96 албан хаагч 24 цагаар ажилласан байна.

- Албан хаагчдын саналын дагуу ээлжийн амралтын хуваарийг баталж, зэрэг дэв шинээр авах шаардлага хангасан 1 албан хаагчийн материалыг ТАЗСЗ-д хүргүүлэв. Аймгийн вэб сайтад тавих сумын мэдээллийг шинэчлэн хүргүүлэв. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийв.
- Сумын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжих өвс тэжээлийн нөөц бэлтгэх ажлын тендерт шалгарсан ЭБОГИ ХХК-д гэрээ байгуулж, гүйцэтгүүлэн 1000 боодол өвс, 300 уут тэжээл хүлээн авав.
- Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөөний 1-р улирлын хэрэгжилтийг ХЭЗХ-т хүргүүлэв.
- Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төлөвлөгөөний 1-р улирлын хэрэгжилтийг ХЭЗХ-т хүргүүлэв.
- Галын аюулгүй байдлыг хангах тухай үүрэг чиглэлийг байгууллага, ААН-д хүргүүлж, сумын айл өрх, албан байгууллага, нийтийн эзэмшлийн талбайн галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулах хүсэлтийг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газарт тус тус хүргүүлэв.
- Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Тусгаарлах байр бэлтгэх үүрэг чиглэлийг ХААН Мандал ОНӨААТҮГ, ЕБСургуулийн захирал эрхлэгч нарт өгч, зочид буудал, өргөө гэр, дотуур байранд нийт 53 ортой тусгаарлах байрыг бэлтгэв.
- Цэргийн бэлтгэл үүрэгтний шилжилт хөдөлгөөний 1-р улирлын мэдээг Цэргийн штабт хүргүүлэв.
- Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах 7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөөг боловсруулж байна.
- Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулж, ААН-дэд үнийн санал авах тоот хүргүүлэв.
- Боловсролыг дэмжих жил, Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн цахим нээлт зохион байгуулж, цахимаар сургалт сурталчилгааг тогтмол хийж байна.
- Иргэдэд шинэ коронавирусын халдвараас сэргийлэх зөвлөмжийг мэдээллийн самбар болон цахим хуудсаар тогтмол хүргэж байна.
- Сумын Шуурхай штабаас өдөр бүр үйлчилгээ үзүүлж байгаа ААН, байгууллагуудаар эргүүл, хяналт хийж, амны хаалтгүй иргэдэд зөвлөмж өгч, амны хаалтаар хангаж байна.
- Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах хүсэлтэй 3 иргэний материалыг Цэргийн штабт хүргүүлэв.
- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх Нийтийн эзэмшлийн талбайн тохижилтын ажлын тендерт шалгарсан “Ихэр сайхан уул” ХХК-д гэрээ байгуулах эрх олгов.
- Сумын ОНХС-н хөрөнгөөр хэрэгжих Мал эмнэлгийн үйлчилгээний гэрээг 2 нөхөрлөлтэй байгуулав.
- Коронавирусын үеийн бэлэн байдлыг хангах үүднээс эмнэлэгийн 18 ажилтанд 1 удаа хамгаалах хувцас өмсөх талаар сургалт хийв.

- Коронавирусын бэлэн байдлыг хангаж ажиллах урьдчилан сэргийлэх ЭМГ-аас зохион байгуулсан теле хуралд 2 удаа нийт давхардсан тоогоор 38 эмч, мэргэжилтэн хамрагдав.
- Коронавирусын бэлэн байдлыг хангаж ажиллах зураглал гарган батлуулж зураглалын дагуу тусгаарлах болон ажиглалтын байрыг бэлдэж бэлэн байдлыг хангаж ажиллассан.
- Коронавирусын үеийн эмнэлзүйн багуудыг томилж үүрэгжүүлж бэлтгэлийг хангуулав.
- Цагаан хоолой ашиглан ард иргэдэд чиглэсэн короновирусын өвнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгааг явуулын байдлаар түгээж ажиллав.
- 0-5 насны хүүхдийн гэрийн эргэлт 3, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн эргэлтнau 10 удаа хийж зөвлөгөө өгч ажилласан.
- ЭМТөвийн 1 давхарт хүлээн авахад үзлэгийн өрөө нээж эмч нар ээлжээрээ үзлэгээ үзэж байна.
- ЭМТөвийн 1 давхарын коридорт хөтөч ажиллуулан хүмүүсийг орж гарахад зөвлөгөө өгөн гар ариутгал хийлгэж, халуун хэмжих үйлчилгээг үзүүлж байна.
- Коронавирусын эхний тохиолдол илэрсэн Дорноговь аймгийн газар нутгаас ирсэн 15 иргэнийг үзлэгт хамруулан зөвлөгөө өгч гэрт нь тусгаарлаж ажилласан. Тусгаарлаж, ажиглах явцад эмнэлзүйн шинж тэмдэг илрээгүй.Төрийн албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор витамин, халуун чацаргана, дархлаа дэмжих бэлдмэл, 5 ээлжийн амны хаалтаар хангав.
- 2020 оны татварын орлогын гүйцэтгэлийн журмаар батлагдсан маягтын дагуу баталгаажуулалтын мэдээг төрийн сантай баталгаажуулан 2020 оны 03 дугаар сарын 06-нд судалгааг гарган холбогдох газарт нь өгсөн.
- Хүн амын орлогын албан татвар төлөгч цэнхэр дэвтэртэй иргэдэд нэхэмжлэх үүсгэв. ААН болон иргэнд буруу үүссэн нэхэмжлэхийг залруулах судалгаа мэдээг хийж 7 хоног бүрийн 5 дахь өдөр судалгааг гарган хүргүүлэв.
- Татварын улсын нэгдсэн систем шинэчлэгдэж байгаатай холбоотой ААН иргэдийн бүртгэл хийв. Цахим болон утсаар зөвлөгөө заавар өгөв.
- Нийгмийн халамжийн чиглэлээр: нийгмийн халамжийн тэтгэвэрт 30 иргэн 5.631.670 төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжинд 50 иргэн 5.181.500 төгрөг, алдар цолтой ахмад настан 1 иргэнд 200000 төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 13 иргэн 596,130 төгрөг, цалинтай эхийн тэтгэмж 85 иргэнд 4.230,000 төг нийт 185 иргэнд 16.999.510 мян төгрөгний санхүүжилт хийгдлээ.
- Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 12 өрхөд 776.000 төгрөгний эрхийн бичгийн олголт хийгдлээ.
- Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: ХЭДС-с зарлагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 35-с дээш насны иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрүүд зарлагдаж иргэдэд төсөл хөтөлбөрийн зар мэдээ мэдээлэл хүргэж иргэдээс ирсэн төслийг хүлээн авч ажиллаж байна. 3 сарын байдлаар хаан банк теллер, хүн эмнэлэг их эмч, сувилагчийн орон тооны 3-н ажлын байр зарлагдсан.
- Иргэний улсын бүртгэлийн төрсний бүртгэлд шинээр төрсөн 2 хүүхдэд төрсний гэрчилгээ, 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх 1 иргэн, 25, 45 насны сунгалт 3 иргэдэд тус тус биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлсэн.

- Захиргааны журмаар 2 иргэний гэрлэлт цуцласны бүртгэл бүртгэсэн.
- 13 иргэний хэвлэгдсэн иргэний цахим үнэмлэхийг татан авч тараасан.
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд 3 иргэний материалыг бүрдүүлж эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлсэн.
- 2 иргэний газрын гэрчилгээ, 1 иргэний үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ хэвлэгдэн ирснийг эздэд нь олгов.
- Тухайн сард газрын кадастрын ЛМ программ хангамжинд 19 өвөлжөөг нөхөн бүртгэж оруулсан.
- Улсын бүртгэлийн хэлтэсээс 2 ширхэг Э дугаар авч гэрээ гэрчилгээг иргэдэд хүлээлгэн өгсөн.
- 1 иргэний газар эзэмших хугацаа сунгах, 1 хуулийн этгээдийн газрын хэмжээг өөрчлөх, 4 иргэний газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтийн дагуу материалыг бүрдүүлэн авч Засаг даргын захирамжийг гаргуулсан.
- Шинээр баригдаж байгаа Нутгийн Удирдлагын ордны барилгад 1 удаа явцын хяналт хийж ажлын явцыг фото зургаар баталгаажуулан аймгийн ГХБХБГазарт хүргүүлэв.
- Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын албан даалгаварын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид 700 гаруй маск оёсоноос 250ш маск нөөцөнд авч үлдэж үлдсэн маскыг сумын шуурхай штаб болон, эрүүл мэндийн төв, ард иргэдэд хандивласан.
- Сургууль ,дотуур байранд 3 удаа ариутгал халдваргүйжилт хийж тусгаарлах байр зассан.
- Сургууль дээр хариуцлагатай жижүүр гаргаж цаг үеийн мэдээ тайланг өдөр өдөрт нь өгч ажиллаж байна.
- Сурагчдын теле хичээл үзсэн байдалд байнгийн хяналт тавьж ажиллаж байна.
- Хорио цээрийн үед сурагчдыг хөгжүүлэх зорилгоор цахим уралдаан тэмцээнийг зохион байгуулж, багш ажилдын дунд бүтээлийн уралдаан зарласан.
- 3 сард нийт 243 хүнд 88665340 төгрөгний тэтгэвэр олгож, шинээр 2 өндөр насны тэтгэвэр тогтоосон.
- 16 аж ахуй нэгжийн нийгмийн даатгалын тайланг цахимаар шивүүлж цаасан тайланг бүрэн хүлээн авч нийгмийн даатгалын хэлтэст хүргэж ажилласан.
- Нийгмийн даатгалын шинэ хуулийн талаар болон бусад тэтгэвэр тэтгэмжийн талаар давхардсан тоогоор 210 орчим хүнд мэдээлэл зөвлөгөө өгсөн.
- Аймгаас хөнгөлөлттэй үнээр олгож байгаа 850 боодол өвс, 250 уут тэжээлийг татан авч малчин өрхүүдэд тараан олгов.

СЭВРЭЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

- Сумын Засаг даргын 14 захирамж боловсруулагдан гарсан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

- Сумын Засаг даргын зөвлөл болон сумын онцгой комисс энэ сард 2 удаа хуралдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

- Багийн дарга нар хөдөөгийн бүх малчин өрхөөр явж цаг үеийн мэдээлэл хүргэж ажилласан.
- 3 дугаар сарын 9-ны өдөр “Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн нээлтийг цахим хэлбэрээ зохион байгуулж 10 иргэдийг хамруулсан.
- Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид сумын төвийн бүх өрхөөр явж мэдээлэл хүргэн ажилласан.
- Улс аймгийн хэмжээнд хөл хорио тогтоосонтой холбоотой 2 удаа 3-6 хоногийн пост ажиллуулсан.
- Өрх гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд сумын Ахмадын хороо болон нийт ахмадуудын малчин өрхүүдэд төлийн нэмнээ болон малын хошуувч бусад хэрэгслийг багийн дарга нараар дамжуулан хүргүүлээ.

ЕБСургууль: Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан постын гэр барих ажилд 28 хүн оролцсон.

- Хөдөлгөөн хязгаарлах үүрэг гүйцэтгэж хяналтын постонд 28 багш ажилтан хуваарийн дагуу ажилласан.
- Сумын өрх гэр бүл иргэдийн насан туршийн боловсролыг дэмжих жилийн нээлтийн цахим үйл ажиллагаанд 12 багш ажилтан оролцсон.
- Боловсролыг дэмжих жилийн болон Өрх гэр бүл НТБ-ыг дэмжих жилийн төлөвлөгөөнүүдийг хүргүүлсэн.
- Сумаас зарласан “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Аз жаргалтай гэр бүл эссэ бичлэг”, “Хөгжилтэй гэр бүл” гар зургийн уралдаанд нийт 12 хүүхэд оролцсон.
- Сургуулийн захирал сумын онцгой комиссын хуралдаанд 2 удаа оролцсон.
- Монгол Улсын Их Хурлын сонгуульд ажиллах ажилтны судалгаанд 11 багш хамрагдаж мэдээлэл баталгаажсан.
- Теле хичээлийн хамрагдалтыг сайжруулах багш нар сурагчидтайгаа бүрэн холбогдох, даалгаврыг хянах ажлуудыг зохион байгуулж, ажлын тайлан мэдээг нэгтгэн ажиллаж байна.
- Малчин өрхийн сурагчдын Теле хичээлийн хамрагдалтыг тандах судалгааг 3 багийн засаг дарга нарт өгч явуулсан бөгөөд сумын хэмжээнд 117 малчин өрхийн сурагч байгаа бөгөөд Сайншанд баг 52, Бүйлсэн баг 23, Хоолт багт 7 малчин өрхийн хүүхэд хамрагдаж нийт малчин өрхийн сурагчдын 72 % нь теле хичээлд хамрагдаж байна гэсэн судалгаа гарлаа.
- Теле хичээлийн нийт хамрагдалтын хувь өдөр бүр адилгүй байгаа ба нийт 204 сурагчаас тогтмол хамрагдаж байгаа сурагчид 109-124 байгаа бөгөөд 60.3%тай байна.
- Мэргэжлийн хяналтын газрын Боловсрол, Эрүүл мэнд, хүнсний хяналтын хэлтэсээс Сургууль, цэцэрлэгүүдэд ирүүлсэн зөвлөмжийн хариуг хүргүүлсэн
- Сургуулийн дотуур байрыг ариутгаж бага хэмжээний засвар үйлчилгээ хийгдсэн.
- Байгууллагын хариуцлагатай жижүүрийг байнга ажиллуулан хяналт тавин ажиллаж байна.
- Хөгжлийн ирээдүй-3өв хүүхэд ТББайгууллага үүсгэн байгуулж гэрчилгээ, тамгатай болсон.

Цэцэрлэг: 3-р сард Сумын онцгой комисс шуурхай штабын хуралд 2 удаа сууж 2 удаа замын хөдөлгөөнийг хязгаарласан 24 цагийн ростонд ажиллаа. Мөн ар гэр нь боломжтой хүмүүсээ ростонд 1 удаа гарган ажиллуулав.

Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил:

- Багш нартаа Теле хичээлийн хуваарийг хүргэн эцэг эхчүүдтэйгээ хэрхэн харилцаж зөвлөгөө өгч хүүхдийн хичээлийг хийлгэн хамтран ажиллах талаар зөвлөгөө өгч өдөр бүр харилцан ярьж цахим байдлаар тэмдэглэл хөтлөх талаар хүснэгт гарган өгч мэдээлэлийг авч нэгтгэн ажиллаа.
- "Би монгол хүн сэдэвт гар зургийн уралдааныг цахимаар зохион явуулж нийт 19 хүүхэд хамрагдан нас насаар нь байр эзлүүлэн урамшууллаа.
- Хүүхдүүдийн сард хэрэглэх ариун цэврийн хэрэгслүүдийг буцааж тарааж өгч дууссан. Мөн гэрээрээ хичээлээ хийх зорилгоор хичээлийн хэрэглэгдэхүүнийг авч хэрэглэх боломжийг ханган ажиллаж байна.**Эрүүл мэндийн төв:** Аймгийн ЭМГ-аас зохион байгуулсан теле хуралд 16 ажилтан 4 удаа оролцон мэдээлэл, зөвлөгөө зөвлөмжийг сонссон байна.
- Коронавирусын дэгдэлтээс сэргийлэх хариуцлагатай жижүүрийн хуваарийг гарган батлуулан мөрдөж ажилласан.
- Сумын mass msj-ээр сумын нийт Коронавирусээс сэргийлэх зөвлөмжийг 3 удаа иргэдэд сэрэмжлүүлэг мэдээлэл өгсөн байна.
- Мөн ЭМТ-ийн FB хуудсанд Томуу өвчнөөс сэргийлэх, Ам зайлах уусмал хэрхэн бэлтгэх арга, Тусгаарлалт, коронавирусын халдвараас сэргийлэх дээд газраас ирсэн зөвлөмжийг байршуулан ажилласан байна.
- Коронавирусын дэгдэлтээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан тусгаарлах өрөөг стандартын дагуу тохижуулсан байна.Бэлэн байдлын үнэлгээ хийж үзэхэд 81,5%-тай байна.
- Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр хуваарийн дагуу ажиллан мэдээ мэдээллийг цаг хугацаанд шуурхай дамжуулан ажиллалаа.
- Эмнэлгийн эмч ажилчдад халдвараас сэргийлэх, хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах дараалалыг зааж сурган үзүүлэх сургууль хийсэн өдөр бүр хийж сургалтыг 1-2 цаг 16 ажилтанд хийж байна. Мөн 11 цагийн ЭМЯ-ны мэдээлэл сонсголыг өдөр бүр хийж байна.
- Сайншанд Хоолт, Бүйлсэн багуудад 3 эмч багийн даргын хамт 145 өрхөөр 226 иргэнд эргэлтийг жирэмсэн эх болон нярай, өндөр настан ХБИ-дэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж болон явуулын дархлаажуулалт 9 хүүхдэд хийсэн. 06-3 насны 73 хүүхдэд бичил тэжээл тараасан байна.
- Хөдөөгийн багийн 40 эмэгтэйг хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамруулсан байна.

Соёлын төв:

- Улс, аймгийн онцгой комисс, сумын онцгой комиссын шийдвэрүүд гарч хамт олноороо 2 удаа хөдөлгөөнт эргүүл, постонд хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэлээ. Постын гэр барих, тохижуулах ажилд мөн оролцон постонд гарах хугацаандаа орчмын хог хаягдлыг цэвэрлэн зам дагуух архины шилийг түүлээ.
- Нийгэм даяараа хөл хориотой байгаа үед иргэдийн нийгэм соёлын идэвхийг дээшлүүлэх зорилгоор Би цэрэгт байхдаа, Цэргийн дууг хэн сайн дуулах вэ зэрэг онлайн уралдааныг зарлан явуулж дүгнэлээ.
- Монгол цэргийн баярт зориулан байгууллага хамт олноороо видео мэндчилгээ бэлтгэн соёлын төвийн цахим хаягаараа иргэдэд хүргэлээ.
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан Ижийдээ захидал бичээрэй захидалын уралдааныг 2 насны ангилалаар зарлан явуулж 20 захидал оролцож насанд хүрэгчдээс 1р байранд Ц.Баярцэнгэл,

2р байранд Мөнхнаран, 3р байранд Б.Наранцэцэг хүүхдийн насанд 1р байр М.Ариунаа, 2р байр Х.Ундрал, 3р байр С.Үүрцайх нар тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.

- Байгууллагын малчиндаа сар шинийн баярын тавгийн боов, өвс тэжээл, ахуйн хэрэглээний зүйлсийг өглөө.

“Дэмд Од” ОНӨААТҮГазар:

- Өмнөговь аймгийн төрийн аудитын газар 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хяналт шалгалт хийлээ. Санхүүгийн тайланд зөрчилгүй аудит гэрчилгээ дүгнэлт гардан авлаа.
- ХАБЭА-н сургалтыг тогтмол хийж байгууллагын албан хаагчдад өдөр бүр мэдээлэл зөвлөгөө өгч байна.
- Нүүрсний нөөц өнөөдрийн байдлаар 200 тн буюу 2020 оны 04-р сарыг дуустал ажиллах нөөц байгаа.
- Байгууллагын бүх ажилчдад барагшун,салимон, маск гар ариутгагч санитасаар хангаж ажилласан

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

- Хөдөлмөр эрхлэлтийн албанд 1 иргэнийг шинээр бүртгэн ажилласан.
- Сумын сонин болон мэдээ мэдээллийн хэрэгсэл Мөрөөдлийн FM-ээр, 3-н багийн засаг дарга нар иргэдэд мэдээллийг хүргэн одоогийн байдлаар 3 төсөл хүлээн авсан .
- Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 2 иргэнд 4.5 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийг 34 иргэн 3,0 сая, байнгын асаргаа халамж шаардлагатай 7 хүүхдэд 1,2сая , жирэмсэн 14 эхэд 0.4 сая төгрөг, өрх толгойлсон 0-18 насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй 2 иргэнд 0,8 мянган төгрөг цалинтай ээж хөтөлбөрт 102 эхийг хамруулан 5,1 сая төгрөгний санхүүжилтыг тус тус олгон ажилласан.
- Жирэмсэн 5 эх, цалинтай ээж хөтөлбөрт хамрагдах 7 иргэн, нэг удаагийн хөнгөлөлт тусламжинд хамрагдах 3, өрх толгойлсон эхийн тэтгэмжинд хамрагдах 1 иргэний баримт бичгийг шинээр бүрдүүлэн хувийн хэрэг нээн ажилласан.
- Шинээр өрх болсон 2 хүүхдийн мөнгөн тэтгэмжинд хамрагдах өрхийн судалгааг аван дээд байгууллагад уламжлан ажилласан.

Хөдөө аж ахуйн тасаг:

- Тасгийн дарга П.Отгон 3-р сарын 9- 14-ны өдрийн хооронд Сайншанд багийн засаг даргатай хамт Сайншанд багийн уулийн ар, элсний арын айдуудаар явж мэдээ судалгаа авах ажлаар явж 86 айлаар орсон. Мал аж ахуйн өвөлжилт хаваржилтын байдалд хүндрэл гараагүй хэвийн байна. Мал төллөж эхлэж байна.
- 3-р сарын 10-ны өдөр Аймгийн Засаг даргын А/226 тоот захирамжийн дагуу сумын Хэсгийн цагдаатай хамтран архи согтууруулах ундаа худалдаалах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж дэлгүүрүүдээр явж архи согтууруулах ундаа худалдаалахгүй байх талаар мэдээлэл өгч аймгийн Засаг даргын захирамжыг танилцуулан архи согтууруулах ундааг битүүмжилсэн.

- Аймгаас хуваарилагдсан 250 уут хивэг, 450 ширхэг долооцыг татан авч малчдад олгож байна. Онгоц байдлын газраас хуваарилсан 500 боодол өвсийг 3-р сарын 4-с эхлэн малчдад олгож байна.
- Хүнс Хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн албан тоотын дагуу газар тариалан эрхлэгчдээс 5 төрлийн нарийн ногооны 1210 ширхэг үрсэлгээний захиалгыг авч хүргүүлсэн.
- Газар тариалангын зориулалтаар хаших 1 га талбайн хөрсний дээжийг авч аймгн Хүнс Хөдөө аж ахуйн газарлуу шинжилгээнд явуулсан.
- Коронавирус гарч, хөл хорио тогтоосонтой холбоотойгоор сумын хэмжээнд хүнсний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Агьт говь ХХК, Нэмэгт Уул ХХК, Харайхын бор гүвээ ХХК гэсэн 3 аж ахуй нэгжээс авч аймгийн Хүнс хөдөө аж ахуй газарт хүргүүлж байна.
- 7 хоног бүрийн 3 дахь өдөр бүр мал төллөлт, том малын зүй бус хорогдлын мэдээг гаргаж аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газарт хүргүүлж байна. 2020.03.19-ны өдрийн байдлаар 4024 мал төллөсөн, том малын зүй бус хорогдол 261 гарсан байна.
- Алаг цавын нуруу мал эмнэлгийн нэгж нь Сайншанд багт 2 удаа дуудлганд явсан нэг хонь ямаа бэрхтсэн.
- Элсний ар,уулын өврийн айл өрхөөр орж 15 нохойнд туулга,вакцин хийсэн.
- Бүйлсэн багт дуудлга 1 галзуу үнэг устгаж ариутгал хийж Сайншанд багт шөвөг ярын вакцин 2061 ишгэнд тарьсан. Сайншанд, Бүйлсэн багт сэг зэмийн устгал 3000м2 ариутгал хийсэн.
- Мал эмнэлгийн гэрчилгээ 37300 кг махан бүтээгдэхүүн, 420 сүүн сүүн бүтээгдэхүүн, 5800 ш арьс ширний гарал үүслийн гэрчилгээ бичсэн. Боловсруулалт 6800 бог малд хийсэн. “Сэврэй Гурван мөнх” мал эмнэлгийн нэгж нь Хоолт багт дуудлаганд явж 1500 малд тарилга хийсэн байна.

Байгаль орчин:

- 2 сарын 20-ны өдөр айл өрх, албан байгууллагуудыг орчмынхоо хог хаягдлыг цэвэрлэх уриалга гаргаж сумын зарын г рүүппээр сурталчилсан. Айл өрх, албан байгууллага 50 метрийн доторх хог хаягдлыг цэвэрлэсэн.
- Аялал жуулчлалын баазуудад ус ашиглах дүгнэлт гаргуулах тухай албан тоотыг усны тухай хууль, усны эх үүсвэрийг тоолууржуулах тухай журмын хамтаар хүргүүлсэн.
- Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгааг маягтын гаргаж БОАЖГазарт хүргүүлсэн.

Газрын харилцаа:

- Газар өмчлөгч иргэний хамтран өмчлөл салгах 3 иргэний өргөдөлийг засаг даргын захирамж гарган холбогдох матриалын хамт иргэд өгч улсын бүрдгэлд явуулсан.
- Булган сумын нутагтай хилийн цэсийн маргаантай 3 өрхийн Булган сумтай тохиролцон сумаас олгосон захирамжийг 03 дугаар сарын 16 ны өдрийн А/34 дүгээр захирамжаар хүчингүй болгон холбогдох матриалын хамт хүргүүлэв.
- ЛМ программд газар ашиглагч 10 иргэний нөхөн бүртгэл хийгдэж газар ашиглах 6 иргэний хугацаа сунгах, мөн газар ашиглах эрх шилжүүлэх 3 иргэний хүсэлт хүлээн авсан.

Нийгмийн даатгал:

- Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 138 иргэн хамрагдаж 17020,4 мянган төгрөг,эрүүл мэндийн даатгалд 80 иргэн хамрагдаж 3211,2 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэн ажилласан.

- Тэтгэврийн даатгалын сангаас Өндөр нас тахир дутуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг ХААН банкаар 261 иргэнд 277 275,3 сая төгрөг, Төрийн банкаар 20 иргэнд 19 916,3 сая төгрөг, 1991-1994 онуудад хөнгөлөлттэй нөхцлөөр тэтгэвэрт гарсан 33-н ахмадад 4950 000 -ийн тэтгэврийг олгосон. Шинээр өндөр насны тэтгэвэрт 1 иргэн гарч тэтгэвэр тэтгэмжиндээ хамрагдсан.
- Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний тэтгэмжийг 2 иргэнд 4504,8 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон.
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 1 иргэнд 330,3 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон.

Татвар:

- Татварын ерөнхий газраас явуулж байгаа онлайн болон бусад сургалт сурталчилгааны мэдээллийг 127 иргэн болон аж ахуйн нэгжид түгээн ажиллаж байна. Мөн Татварын поргарамм шинчлэгдсэнтэй холбоотой иргэдийн мэдээллийг засах шинээр код авч бүртгүүлэх ажилд 82 иргэнийн мэдээллийг шинэчлээд байна.
- Улсын төсөвт 1,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,4 сая төгрөг төвлөрүүлж 133 хувьтай
- Аймгийн төсөвт 10,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 5,6 сая төгрөг төвлөрүүлж 56 хувьтай, Орон нутгийн орлогод 6,7 сая төгрөг төвлөрүүлэхээс 16,0 сая төгрөг төвлөрүүлж 239 хувьтай тус тус төвлөрүүлсэн байна.
- Багуудын өрхийн ногдлыг боловсруулан гаргаж багийн дарга нарт хүргүүлэн ажилласан

Улсын бүртгэл:

- 03 сарын 19-ний байдлаар өссөн дүнгээр иргэний гэр бүлийн байдлын төрсний бүртгэлд 6 хүүхэд
- Гэрлэлт цуцлалтын бүртгэлд 1 хос, Нас барсны бүртгэлд 1 иргэн, Иргэний шинэчилсэн бүртгэлд 16 иргэн, Иргэний үнэмлэх үрэгдүүлж захиалсан 3 иргэн, Цахим үнэмлэх 29 иргэнд, Дахин олголтын гэрчилгээ 1 иргэнд, Лавлагаа 3 иргэнд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхны бүртгэлд 1-н иргэн тус тус бүртгэж гэрчилгээг олгосон.

ХҮРМЭН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

- Зорчих хөдөлгөөнийг хязгаарлах тухай, Архи согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох тухай, Зардал гаргах тухай гэсэн нийт 10 захирамж, зардал гаргах тухай 1 тушаал тус тус гарган ажилласан.
- Орон нутгийн удирдлагаас гарсан шийдвэрийн дагуу сумын хэмжээнд халварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэл, ариутгалын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

- Сумын Онцгой комисс хуралдаж 3 удаа хуралдаж тусгай төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэн, шаардлагатай тохиолдолд ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, шатахуун тослох материалын нөөц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

- ЕБСургууль: Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг гаргахгүй байх чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, байгууллагын цахим хаягаар багш, ажилчдад, багш нар эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөмж зөвлөгөөг хүргэж ажиллаж байна.
- Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж байна.
- Товлолын дархлаажуулалтад 14 хүүхэд хамруулсан байна. Томуугийн сайн дурын дархлаажуулалтанд 20 хүн хамрагдсан.

Цэцэрлэг:

- Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг гаргахгүй байх чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, байгууллагын цахим хаягаар багш, ажилчдад, багш нар эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөмж зөвлөгөөг хүргэж ажиллаж байна.

Соёлын төв:

- Улс болон аймгийн хэмжээнд урлаг соёл, спорт, хурал зөвлөгөөн, олон нийтийг хамарсан арга хэмжээг хориглосонтой холбогдуулан Соёл спортын төвөөс төлөвлөсөн ажлууд тодорхой хугацаагүйгээр хойшлогдож, зарим ажлууд цуцлагдсан.

Газрын харилцаа:

- Газрын кадастрын мэдээлэлийн сангийн Вэб, Лэнд менежер программ руу өмчлөлийн 15 , эзэмшлийн 30 нэгж талбар нөхөн бүрдүүлэлт хийсэн.
- Хүрмэн суманд газар өмчилж аваагүй гэсэн тодорхойлолт 2 иргэнд гаргаж өгсөн. Газрын кадастрын мэдээлэлийн сангийн Вэб, Лэнд менежер программд орсон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч хуулийн этгээд, иргэний хүчинтэй 65 гэрээнд газрын төлбөр, татварын нэхэмжлэлийг үүсгэсэн.
- Газрын төлбөр, татварыг цахимаар төлөх болсонтой холбоотой 25 иргэнд зөвлөгөө зааварчилгаа хүргэсэн. Газар эзэмших иргэний 15 гэрээг дүгнэж гэрчилгээ, гэрээг шинэчилсэн. Газар эзэмших эрх дуусгавар болох 1 иргэний хүсэлт, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлэх 3 иргэний хүсэлтийг тус тус хүлээн авсан.

Хөдөө аж ахуй:

- Сумын хэмжээнд хэмжээнд 400 малчин өрх , мал бүхий өрхийн 169 мянган толгой хаваржиж байна. Нийт мал сүрэг 40-45 хувийн тарга хүчтэй нийт 2565 мал төллөсөн үүнээс ингэ 102,гүү 2, үнээ 8, эм хонь 1727, эм ямаа 728 төллөж гарсан төл 100 хувь бойжиж байна.
- Сумын хэмжээнд нийт бэлчээрийн 40% нь өвстэй, 30% нь дунд зэрэг, 30% нь тааруу байна.

- 92 өрхийн 451 ботгонд 2255000 төгрөгний урамшуулал олголоо.
- Дорноговь аймгийн Богд суманд 1 өрхийн 1200 толгой мал отроор явж байна
- Аймаг дотроо 10 өрхийн 5,0 мян толгой мал бусад сумдад оторлож явна. Тусгай хамгаалалттай газар нутагт 5 өрхийн 3,2 мян толгой мал хаваржиж байна.
- Сумын хэмжээнд 3 сард 27 тн өвс, 22 тн тэжээл татан авч малчидад хөнгөлөлттэй үнээр олгож, 7 тн тэжээл 5тн өвс аймгийн нөөцөөс татан авч төвлөрүүлээ.

ХАНХОНГОР СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

- Сумын засаг даргын 9 захирамж гарсан. Үүнээс өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай -1, сумын алдарт уяачид цол олгох тухай-1, хөрөнгө зарцуулах тухай-4, ажлын хэсэг байгуулах-2, зорчих хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай-1, Засаг даргын тамгын газрын даргын тушаал 5 гарсан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

- Сумын онцгой комисс 3 удаа хуралдсан. Мал эмнэлэгийн гарал үүслийн гэрчилгээ болон зарим ажил үйлчилгээний арга хэмжээ цахим системд орж байгаатай холбогдуулан нэгжийн болон тасгийн эмч нар мэдээллийн цахим системийн сургалтанд хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ:

- Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдсан. Хурлаар Төрийн болон аймгийн шагналд тодорхойлох тухай, Нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолт хүргүүлэх тухай, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Тэргүүлэгчдийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай“, Цагаан дэл уул – Өлзий хилийн боомтын ажлын хэсэг байгуулах тухай, Үндсэн хөрөнгө актлах тухай, санал хүргүүлэх тухай, Сумын бар наадам, Ерөнхий боловсролын сургуулийн 80 жилийн ойг товллох тухай, Олон нийтийн оролцоот Сургууль хөтөлбөр батлах тухай, Алдарт эхийн одонгийн материал хэлэлцэх тухай, Цэргийн дүйцүүлэх алба хаах нэрс батлах тухай , Сонгуулийн хэсэг байгуулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн М.Цэцэгбадам багшаас ирүүлсэн өргөдөл танилцуулж шийдвэрлэх тухай, Төрийн болон аймгийн шагналд тодорхойлох тухай тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн.
- Шинэ коронавирусын халдвараас хамгаалах ажлын хүрээнд сумын онцгой комиссоос 2 удаа хуралдаж үүрэг чиглэл өгч ажиллалаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн Монгол Улсын Засгийн газрын болон улсын онцгой комиссын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын онцгой комиссоос нийт 6,8 сая, сумын засаг даргын нөөц сангаас 1,8 сая төгрөгийг сумын эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгсэлд зарцуулаад байна. Сумын шуурхай штабыг ажиллуулж байна.
- Улсын онцгой комиссын тогтоолын дагуу зорчих хөдөлгөөнийг 2 удаа хязгаарлалтын дэглэмийг зохион байгуулан ажиллалаа.

- Сумын эрүүл мэндийн төв коронавируст халдвараас сэргийлэх тушаал шийдвэрүүд болон хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах дарааллын талаар нийт 9 удаа эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. Мөн эрүүл мэндийн цахим хуудсанд 75 нэр төрлийн зөвлөмж, зөвлөгөө байршуулсан. Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан шинэ коронавирусын үед авах арга хэмжээ, бэлэн байдлыг ханган ажиллах талаар аудио хуралд 7 удаа зохион байгуулагдан давхардсан тоогоор нийт 48 эмч ажилчид хамрагдлаа. Өгөөмөр багийн 3 малчин өрхөөс Улсын мал эмнэлэгийн лабораториос 100 тэмээнээс цусны дээж авч шинжилгээнд хамруулсан. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 3430 мал амьтан хамрагдсан. Паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 5000 мал хамрагдсан. Мал эмнэлэгийн дуудлага үйлчилгээг 32 өрхийн 305 малд хүрч үйлчилгээ үзүүлсэн байна. Мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тарилга вакцинаа татан авч хийж эхлээд байна. Шалтгаан нь тодорхой бус үхсэн 2 үнэгийг устгаж шатаан булсан.
- Мэргэжлийн сургалттай сургуулийн хүнсний агуулах барих тендерийг зарласан. Сумын Засаг дарга засаг даргын орлогч, багийн засаг дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулан, байгууллагын дарга эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж баталгаажууллаа. “Өрх гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” “Боловсролын салбарыг дэмжих жил”-ийн хүрээнд ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөгөө батлуулан ажиллаж байна. Заавал хөгжих 30 өрхийг сонгож суурь судалгаа хийсэн. “Нэг өрх - нэг ажлын байр”-ны судалгааг 10 өрхийн судалгаа, Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй өрхүүдэд цаасан талоныг олгож тайлан, Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд 2 өрхийн судалгааг тус тус ХХҮГазар руу хүргүүлсэн. “Энержи ресурс” ХХК-тай хамтран ажиллах гэрээний дагуу 2018, 2019 онд хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтын ажлаа танилцуулан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцлоо. 10-р цэцэрлэгийн хамт олон гэрээр хүүхдэд даалгавар өгч ажиллаж байна. Мөн зан үйлийн өргөөнд дугалуур ширж тохижуулсан байна. Мэргэжлийн сургалттай сургуулиас теле хичээлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. Цахим тандах шалгалтыг зохион байгуулж үр дүнг танилцууллаа. Ардын уламжлалт өргөөг тохижуулж байна. Байгууллагын хэсэгчилсэн хурлыг 3 удаа зохион байгуулсан. Видео хичээлийн бэлтгэл ажлыг хангаж байна. Хоцрогдож байгаа судлагдахуун болгоны анхаарах сэдвийн жагсаалтыг гаргасан. Дотоод хяналтыг зохион байгуулж хугацаа дууссан бүтээгдэхүүнийг устгалд оруулсан. Элсэлтийн ерөнхий шалгалтын ажлын хэсгийг байгуулан үүрэг чиглэл өгсөн. Онлайн шалгалтын сэдэв боловсруулах ажил хийгдэж байна. Байгууллагууд ариутгал халдваргүйтлыг 1-3 удаа зохион байгуулсан байна.
- Хүүхдийн төлөө зөвлөлийн 2020 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. 2019 оны заавал хөгжих өрхийн онлайн судалгааг шивж оруулсан. 2019 оны хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлэн аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Байгууллагын дотоод журамд Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг үндэслэн нэмэлт заалт, Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэмэлт заалтыг тус тус боловсруулж оруулсан.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан

Шинэлэг ажил:

- Шинэ коронавирусын өвчлөлтэй холбоотой олон нийтийн болон бусад арга хэмжээнүүд зохион байгуулахгүй байна.

Бусад ажил:

- Шинэ вирусээс хамгаалах тухай мэдээ мэдээллийг иргэдэд цахимаар байнга хүргэж анхааруулж ажиллаж байна. Мөн сумын онцгой комисст байгууллага, иргэдээс хандив ирсээр байна. Нийт даавуун маск 685, нэг хэрэглээний макс 40ш, N95 маск 25ш болон бусад дархлаа дэмжих чацаргана шүүсийг хандивласан. Төсөл хөтөлбөрт хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээ “Маскжуулах аян”-д уриалан нийт 8 иргэн 165 ширхэг маск оёж сумын онцгой комисст хүлээлгэн өгсөн. Мөн нийт 2100,0 мян төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Тус мөнгөөр эргүүл постонд ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор дотоод станц 4 ширхэг, гэрэлтэй дохиур 2ш, цацруулагчтай хантааз зэргийг авсан. Мөн сумын Эрүүл мэндийн төвийн түргэний автомашинд засвар хийхэд зориулсан байна. БСШУСЯ-аас зарласан “Соёлын төв-Чанартай үйлчилгээ” уралдааны тайланг сумын Соёлын төвөөс хүргүүлсэн байна.

Багт хийгдсэн ажил:

- Малчдад улсын болон орон нутгийн нөөцөөс өвс тэжээл хуваарилсны дагуу мал бүхий 496 өрхөд 830 боодол өвс, 570 шуудай тэжээлийг татан авч хүргүүлсэн.

ЦОГТ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн

- Сумын ИТХТ-ийн ажлын албанаас шинэ төрлийн корона вирус халдвар урд хөршид гарсантай холбогдуулан ИТХ, ЗДТГазраас ард иргэддээ хандаж “Мөнхийн хөршдөө сэтгэлийн дэмжлэг” уриалга гаргасан.
- Энэ сард сумын ИТХурлаас тогтоол гараагүй байна. Засаг даргаас А захирамж 5, Б захирамж 2, ЗДТГазрын даргын А тушаал 8 гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

- Сумын Засаг дарга байгууллагын дарга эрхлэгч болон багийн засаг дарга орлогч, тамгын дарга нартай гүйцэтгэлийн гэрээ байгуулсан.
- 2020 оны 03 сарын 10-ны өдөр Сумын Онцгой комиссыг 11.00 цагт 14 хүний бүрэлдэхүүнтэй хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэн гаргалаа. Үүнд: 24 цагийн болон хөдөлгөөнт пост гаргах ажлыг 3 сарын 10-ны өдрөөс 3 сарын 16 хүртэл ажиллуулж зам дагуу нийтийн хоолны газруудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох, сумын Шуурхай штаб 24 цагаар ажиллах, сумын төвд хариуцлагатай жижүүр ажиллуулах, тусгаарлах байр бэлтгэх, иргэдийг мэдээ мэдээллээр хангах, постонд гарах шатахуун, хоол хүнсний нөөц, санхүүгийн тооцоо судалгаа гарган ажилласан.

- Сумын онцгой комисс 2 удаа хуралдаж шуурхай штабыг 24 цагаар ажиллуулж албан хаагчдыг хуваарийн дагуу гаргаж аймгийн шуурхай штабад 4 цаг тутамд мэдээ өгч шуурхай мэдээг өдөр тутам өгч өндөржүүлсэн бэлэн байдалтай ажиллаж байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ:

- Өмнөговь аймгийн хэмжээнд 2020 оныг өрх гэр бүлийн хөгжлийн жил салбарын хувьд Боловсролыг дэмжих жил болгон зарласны дагуу сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэгийг тус тус байгуулж Өрх гэр бүлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Боловсролыг дэмжих жилийн төлөвлөгөөг тус тус боловсруулж төсвийн байгууллагуудад хүргүүлж үүрэг чиглэл өгч ажиллаж байна.
- Дэмжих жилийн нээлтүүдийг цахимаар иргэдэд хүргэж тухайн жилд хийх онцлох ажил арга хэмжээний санааг иргэдэд хүргэхийг зорьсон. Өрх гэр бүлийн хөгжлийн жил 7 минут 40 секундын бичлэг, Боловсролыг дэмжих жил-1 минут 40 секундын бичлэгийг хийж иргэдэд цахимаар хүргэсэн.
- Өрх гэр бүлийн хөгжлийн жилийн хүрээнд “Хөгжих боломжтой зөвхөн нэг өрхөд орон сууц барих” ажлыг нээлттэй хэлбэрээр явуулж 03 сарын 05-наас 03 сарын 16-ныг хүртэлх 10 хоногийн хугацаанд цахимаар зарлаж иргэдээс санал авч ажиллалаа. Энэ хугацаанд иргэдээс 22 өрхийн нэрийг 256 иргэн нэр дэвшүүлсэн байна.
- 2020 оны 03 сарын 18-ны өдөр ажлын хэсэг 100%-ийн бүрэлдэхүүнтэй хуралдаж сумын Засаг дарга Э.Чойжилсүрэн 22 өрхийн танилцуулга хийж шалгуур үзүүлэлт бүрэн хангасан 4 өрх дээр нууцаар санал хураалт авч Замын шанд багийн иргэн Ө.Хүрэлбаатарынх шалгарсан байна.
- Эрүүл мэндийн төв нь “Шинэкорона вирусын эсрэг” 02 сарын 23-наас 03 сарын 16-ыг хүртэл 24 цагаар эмч, мэргэжилтэн нар 19 хоног сумын төвийн “төв замын постонд” 24 цагаар хуваарь гарган Улаанбаатар-Өмнөговь чиглэлд, Өмнөговь-Улаанбаатар чиглэлд зорчин өнгөрсөн хүмүүсийн биеийн халуун үзэж, иргэдийн маск зүүсэн эсэхэд хяналт тавьж ажилласан. Энэ хугацаанд нийт 3000 автомашины 11288 зорчигч биеийн халууныг үзэж ажилласан байна.
- Цогт-Овоо сумын 2020 оны төсөвт төвлөрүүлэх орон нутгийн орлогын 1 сарын төлөвлөгөө - **2,992,1** гүйцэтгэл - **8544523,12** төгрөг орж **285,5%** -тай төлөвлөгөөг даван биелүүлсэн. 2020.01.28-ны өдөр Цогт-Овоо сумын татварын албанаас аймгийн татварын хэлтсийн татварын байцаагч нартай хамтран сумын нийт ААН-үүд, хүнсний дэлгүүрүүдээр явж, НӨАТ-ын И-баримт хэвлэлтэнд хяналт, шаардлага тавьж нийт 11 дэлгүүрээс 7 нь баримт өгдөг болгосон.
- 2019 оны ХХОАТ-ын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэн буцаан олголт авах нийт 16 татвар төлөгчдийн тайланг баталгаажуулсан.
- Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, Улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрээр Зорчих хөдөлгөөний түр хязгаарласантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны А/23 тоот “Зорчих хөдөлгөөн түр хязгаарлах тухай” Захирамж гарч, сумын хэмжээнд 3 байнгын ажиллагаатай, 1 хөдөлгөөнт нийт 4 пост гарч ажилласан.
- Аймгийн Засаг даргын 2020 оны 03 сарын 10 саоын өдрийн А/226 дугаар захирамжийг Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, дэлгүүрүүдэд тарааж,

архи худалдаалж буй эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Энэ хугацаанд гарсан зөрчилгүй.

- Шалган нэвтрүүлэх 4 постонд Цагдаагийн 5 албан хаагч, ЭМТөвийн 16 эмч, мэргэжилтнүүд, ЗДТГ-ын болон бусад төрийн байгууллагын 36 төрийн албан хаагчид, нийт 57 төрийн албан хаагчид үүрэг гүйцэтгэлээ.
- Энэ хугацаанд 24 цагийн ажиллагаатай постонд гарч буй албан хаагчдын хоолыг өдөрт 2 удаа ЕБСургууль, 12-р цэцэрлэгийн багш, ажилчид ээлжээр хийж өгсөн, тухайн байгууллагууд өөрсдөө зардал мөнгийг бүрэн хариуцсан.
- Нийт зардал 150 литр шатахуун зарцуулсан. ЭМТөвийн шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэхэд-1 сая төгрөг, Хамгаалалтын хувцас болон 1 удаагийн маскны нөөц бүрдүүлэхэд 932.000 төгрөг. Нийт 2.215.500 төгрөг зарцуулсан. /сумын хэмжээнд хүний нөөц, төсөв санхүүгийн нөөцийг хэмнэх тал дээр анхаарч ажиллалаа. /
- 2020 оны 03 сарын 10-ны өдрөөс 2020 оны 03 сарын 16-ны 07 цаг хүртэл сумын постуудаар нийт702..... тээврийн хэрэгсэл, ...1559.. хүн нэвтрэн гарсан. Буцаасан тээврийн хэрэгсэл-3 байсан. Нэвтрэх хуудсаар буюу тусгай зөвшөөрөлтэй тээврийн хэрэгслүүдийг постуудаар нэвтрүүлсэн болно.
- Гарсан зөрчил дутагдал- 3 тээврийн хэрэгслийг буцаасан, зөвшөөрөлгүй нэвтрэхээр оролдож, зугтаасан асуудал гарсныг цагдаагийн абан хаагчид илрүүлсэн.
- Сумын Засаг даргны захирамжаар ажлын цагийг богиносгох шийдвэр гарч 09-12 цаг, 14-17 цаг болгосон. Төрийн албан хаагчдынхаа дархлааг дэмжих зорилгоор сумын ИТХурал, ЗДТГазраас ажилтан албан хаагчидаа Зөв аарцны ундаа, Өтгөрүүлсэн чацарганы шүүс 275.000 төгрөгийн үнэ бүхий зүйлсийг 25 албан хаагчдад олгосон. ЭМТ-ийн эмч, ажилчдын дархлааг дэмжих зорилгоор хувь хүн 24литр айраг тус хамт олонд хандивласан.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ:

- ЕБСургууль нь Теле хичээлийн хуваарийг багш нарт сургуулийн фэйсбүүк хаягаар өгч АУБ нар ангийн группээрээ эцэг эх хүүхдэд хүргэж өдөр бүр онлайн жижүүр багш ажиллаж ирцийг авч сургалтын менежерт нэгтгэж өгснөөр БСУГ-т 7 хоногоор нэгтгэн мэдээлж байна. Теле хичээлийн ирц - 62.5% -аас 72,4 % -тай байгаа нь 2 сараас 2,5 %-аар буурсан байна.
- 12-р Цэцэрлэг нь теле хичээл болон эрүүл мэнд, хооллолтын талаарх 40-өөд мэдээ мэдээлэлийг эцэг эхчүүдэд цахимаар хүргэж ажилласан байна.
- Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж сумын онцгой комисс Засаг даргын нөөцөөс 1,401,000 төгрөгний ариутгал халдваргүйжүүлэлтын ажил зохион байгуулж 164 өрхөд 164 кг хлорын шохой, 222 өрхөд 2220 ширхэг жавьлоны уусмалыг тарааж ариутгал хийж нийт өрхийг халдваргүйжүүлж ажилласан.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд:

- Аймгийн нөөцөөс 800 боодол, 288 ширхэг хивг тэжээл татан авч малчдын хаваржилтын бэлтгэл ажлыг хангалаа. Эдгээр өвс тэжээлийг зөвхөн тээврийн хөлсийг шингээн өрх бүрт хуваарилж өгсөн.

ХАНБОГД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

- Ирсэн бичиг-150, Хугацаа хэтэрсэн-0, Шийдвэрлэсэн-130, Өргөдөл, гомдол-50, Засаг даргын захирамж А-25, Б-2, Засаг даргын тоот-125, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-А-1, Б-0, Засаг даргын Тамгын газрын даргын Шуурхай хурал-1, ИТХ-ын тогтоол -0 тус гаргасан байна. СОК-ийн хуралдаан 4 удаа хуралдсан байна.

Хоёр. Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

- Хөл хорио болон вирүсийн дэгдэлтээс сэргийлэх зорилгоор СОК-ын хуралдааныг 4 удаа хийж шаардлагатай үүрэг даалгаварыг холбогдох байгууллага бүрт даалгаж ажилласнаас тусгаарлагдсан 1 иргэнийг СДЭ амжилттай хяналтанд байлгаж өнгөрүүлсэн ба олон нийтийн үйл ажиллагааг хянаж аймгийн Засаг даргын 4 сарын 1 хүртлэх гаргасан шийдвэрийг хяналтанд аван одоогоор зөрчилгүй ажиллаж байна. Цагаан хад дахь нүүрс тээврийн үйлчилгээ Гашуун сухайт боомтоор тээвэрлэх ажлын бэлэн байдлыг хангаж эхлүүлсэн.
- Бүх төрийн байгууллагын ажилчдыг өндөржүүлсэн бэлэн байдлын үед бэлтгэлтэй ажиллах, ээлжээр хяналт тавин эргүүлд гарч ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна. Төрийн болон нийтийн үйлчилгээний газруудад ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж Цагаан хад болон Сумын төв орчмын нохой устгалын ажил хийгдэж нийт 250 орчим нохойг усгаж ариутгалыг хийж ажилласан.
- Нийт малчид болон мал бүхий иргэдэд хаврыг өнтэй туулхад зориулан сумын өвс тэжээлийн нөөцийг бэлтгэн ажилласнаас малчидад тараан өгч хорио цээрийн дэглэмийн үед захиалга үүсгэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ариутгал халдваргүй байдлыг сахин ЗДТГ болон сумын нийт ААНБ-ууд нэг удаагийн маскийг зүүж гар ариутгах бодисыг сайн хэргэлэж занших цахим сургалтыг зохион байгуулсан.
- Нүүрс тээвэрлэлт болон баяжмалын цувааг явуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласнаас УОК-ын бүрэлдхүүн, Зам тээврийн сайд Б.Энх-Амгалан, Аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нар газар дээр нь үйл ажиллагаатай танилцаж заавар зөвөлгөө чиг үүргийн СОК, ЗДТГ-т өгч 2020 оны 3 дугаар сар 23-ний өдрөөс эхлэн тээвэрлэлтийг эхлүүллээ.

Сум дундын эмнэлэг:

- Шинэ коронавирусын өвчний талаар тухайн цаг үеийн мэдээлэл, сурталчилгааг Ханбогд сум дундын эмнэлгийн page хуудсанд өдөр бүр тогтмол байршуулж байна.
- Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт өдөр бүр томуугийн мэдээг 7-8 цагийн хооронд мэдээлэлж байна.
- Коронавирусын талаар сургалтын материал 225 ширхэгийг тарааж мэдээлэл өгсөн.
- ЭМГ-аас жил бүр зохион байгуулдаг “давсны хэрэглээ” сэдвээр эмнэлгийн page хуудсаар зурагт хуудас, гарын авлагыг байршуулсан.
- Постонд 6 эмч, ажилчид 12 цагаар ээлжилж 24 цагийн турш сумаас орох, гарах иргэдийн халуун үзэж ажилласан.

- Цагаан хаданд тусгаарлагдсан иргэдийн байранд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж цэвэрлэсэн.
- Сумын ХААН банкны тооцооны төвийн хамт олон ОУЭ-ийн эрхийг хамгаалах өдрийг угтаж эмнэлгийн нийт ажилчдад баяр хүргэж дурсгалын зүйл өгсөн.
- Их Өлзийт Цагаан-Уул ххк-с 40 ширхэг даавуун маск /амны хаалт/, гарын саван /safeguard/, comet зэргийг эмнэлэгт өгсөн.
- Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлж эмнэлгийн эмч, ажилчдад 10 цагаас халуун аарц, чацарганыг тогтмол уулгаж байна.
- Оргилдоржшүг эм эргэлтийн сан нь эмнэлгийн бүх ажилчдад дархлаа дэмжих салимон, витамин С, витагриппийг өгсөн.
- Анар эмийн сан эмнэлэгт утлагын аппарат, 5 литр спирт, гар ариутгалыг өгсөн.
- Нүүрс тээвэрлэлт эхлэхтэй холбогдуулан жолооч нарын урьдчилан сэргийлэх үзлэгийг 2020 оны 3 дугаар сарын 16-18ны хооронд хийгдэж нийт 114 хүмүүсийг лабораторийн шинжилгээ, рентген зураг, зүрхний цахилгаан бичлэгийг хийсэн.
- 3 сард сумын эмнэлэгт 5 эх эсэн мэнд амаржаад байна.
- 2020.01.28 -2020.03.01 хүртэл эргүүлийн хуваарь гаргаж, өдөр бүр багш ажилчид 2, 2-оороо Гоёот, Хөөвөр, Галбын наран гэсэн газруудаар тогтмол эргүүл хийж гадуур явж байгаа хүүхдүүд болон хүмүүст хяналт тавьж ажиллаж, зөвлөгөө зөвлөмжийг тараасан.
- 2020 оны 02.11 нд Сумын онцгой комиссоос өгсөн N95 загварын 40 ширхэг маскийг багш ажилчдадаа тарааж өгсөн.
- 2020.02.17 нд байгууллагын бүх ажилчдад амны хаалт, витамин тарааж өгсөн. 60 ш маск, 30 ширхэг витамин тарааж өгсөн.

Сургууль:

- Теле хичээл үзэж байгаа сурагчдын оролцоо, тэмдэглэл, хүүхдийг хараа хяналттай байлгах, аюулгүй байдлыг хангах талаар эцэг эх асран хамгаалагчтай холбогдож зөвлөгөө өгч, судалгаа гаргаж, багш нарын ажлын цагийг тооцож ажиллахыг Д. Баярмаад даалгаж ажиллаа.
- Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж зөвлөгөөг багш сурагч, нийт эцэг эхчүүдэд олон нийтийн сүлжээ, үүрэн телефон ашиглан 1 –р сарын 09-өөс 3-р сарын 22-ийг хүртэл манай эмч, нийгмийн ажилтан, ангийн багш нар хамтран цаг тухайд нь хүргэж МХГ-ын Ариутгал халдваргүйжүүлэх зөвлөмжийн дагуу сургуулийн орчинд цэвэрлэгээ хийгдсэн,
- 3-р сарын 18 нд мэргэжлийн байгууллагаар халдваргүйжилтийн ариутгалыг сургуулийн эзэмшилийн бүх талбай анги танхимдаа хийлгэлээ.
- Ангийн багш нар сурагч, эцэг эхчүүдтэй нийтийн цахим сүлжээ, гар утас зэргээр холбогдож, теле хичээлтэй холбоотой мэдээлэл хүргэх, эргүүлээд гүйцэтгэлийн явцын мэдээ авах байнгын холбоо үүсгэж ажиллаа. Өнгөрсөн 3-р сард 3 долоо хоногийн теле хичээлийг манай сургуулийн 710 суралцагчаас 522 сурагч үзэж, тэмдэглэл хөтөлсөн, гүйцэтгэлийн хувь 73.5 байна.
- Нийт суралцагчдын эцэг эхчүүдтэй онлайн цахим сүлжээ, гар утас зэргээр холбогдож, суралцагчдын эрүүл мэнд, осол гэмтэлээс урьдчилан сэргийлэлт, эрүүл аюулгүй орчин нөхцөл бүрдүүлэлт, хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгааг авч, тэдгээр суралцагчидтай хэрхэн ажиллах төлөвлөгөөг гаргаж, тусгайлан зөвлөн ажиллаж байна.

Цэцэрлэг:

- 2020.02.22 -2020.03.22 хүртэл эргүүлийн хуваарь гаргаж, өдөр бүр багш ажилчид 2, 2-оороо Гоёот, хөөвөр, галбын наран гэсэн газруудаар тогтмол эргүүл хийж, дэлгүүрүүдэд захирамж зөвлөмж өгч, гадуур явж байгаа хүүхдүүд болон хүмүүст хяналт тавьж ажиллаж, өвчлөлийн талаарх зөвлөгөө зөвлөмжийг тарааж эргүүлийг илтгэх хуудсыг цаг тухай бүрт нь илгээж ажиллаж байна.
- 2020.03.15 байгууллагын бүх ажилчдад амны 2ш амны хаалт тарааж өгсөн
- Бүлгийн багш 1, 2, 3 саруудын ахуйн хэрэглээг хүүхдүүддээ буцааж өгсөн.
- Бүлгийн багш, туслах багш нар хамтран хүүхдүүдэд 2 удаа гэрээр хийх даалгаварыг бэлтгэж тараасан.
- 2020.03.13 шалган нэвтрүүлэх 6 цэгүүдэд эргүүлд гарч хүмүүст 3 удаа хоол хийж хүргэж өгсөн.
- 2020.02. Сумын онцгой комисс-т хамт олны дундаас 200ш амны хаалт өгсөн.

Бусад ажлууд:

- Иргэд, ААНБ-аас өндөржүүлсэн бэлэн байдлын үед иргэд болон төр захиргааны байгууллага, СОК, УОК-т шаардлагатай эд зүйлсийг өгч байгаатай холбогдуулан хандивын шилэн дансыг нээж холбогдох байгууллагад хүлээлгэн өгснөөс дурьдвал АОК-т хандив болгон авто тээврийн хэрэгслийн ариутгалын төхөөрөмж, ХӨСҮТ-ийн эмнэлэгт шаардлагатай хамгаалах хэрэгсэл 120л ингэний хоормог зэргийг хүлээлгэн өгч ажилласан.